



НЭЭЛТЭЙ НИЙГЭМ ФОРУМ



2006

ЖИЛИЙН ТАЙЛАН

Жамьян гүний гудамж – 5/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48, Монгол Улс  
Утас: (976-11) 313207, Факс: (976-11) 324857 Веб сайт: <http://www.forum.mn>

## ■ ГАРЧИГ

ӨМНӨТГӨЛ	3
<b>Форумын үйл ажиллагааны чиглэл</b>	<b>5</b>
ЗАСАГЛАЛ	5
Ил тод байдал	6
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	9
Нээлттэй ил тод төсөв	12
Төрийн үйлчилгээний мониторинг	17
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	20
Иргэдийн оролцоо ба мэдээллийн эрх чөлөө	22
Нутгийн болон төвлөрсөн удирдлага	26
Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж	27
Эрхзүйн туслалцаа	28
Стратегийн өмгөөлөл	30
Төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалт	32
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>	<b>33</b>
Эдийн засгийн эрх чөлөөний индекс	34
Монгол Улсын өрсөлдөх чадвар	35
Орон нутгийн эдийн засгийн хөгжил	37
Уул уурхайн салбарын бодлогын асуудал	39
Газрын шинэтгэлийн хэрэгжилт	41
Хөгжлийн бодлогын яриа хэлэлцүүлэг	42
<b>Форумын үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэрэгсэл</b>	<b>45</b>
ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ	46
ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨР	48
ПОРТАЛ САЙТ	52
БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР	55
ХЭВЛЭН НИЙТЛЭЛ	56
БУСАД ХАВСРАЛТ	59
Албадан ажил хийлгэх ялыг хэвшүүлэх төсөл	60
Дорно дорно хөтөлбөр	62
Санхүүгийн тайлан	64
Ажилтнууд	73

## ■ ӨМНӨТГӨЛ

Улиран одсон 2006 он – Монголын тулгар төр эмхлэн байгуулагдсны түүхт 800 жилийн ойн жил байлаа. Өнөөдөр бидний монголчууд ямар хүч чадал, нүүр царайтай байгаа тэр л хэмжээгээрээ энэ ховор тэгш ойг дэлхийн олон улс оронтой хамтран байж тэмдэглэн өнгөрүүлэв. Энэхүү түүхэн ойг тэмдэглэхэд манай байгууллага ч гэсэн өөрийн хувь нэмрээ оруулахыг эрмэлзэн хөдөө, орон нутгийн номын сангуудын сан хөмрөгийг түүх, нийгэм, эдийн засгийн чиглэлээр сүүлийн үед хэвлэгдсэн зохиол бүтээлээр өргөтгөлөө.

Нээлттэй Нийгэм Форум байгуулагдсан цагаасаа эхлэн байнга анхаарлаа хандуулж ирсэн нэг гол асуудал болох Авилгын эсрэг хууль 2006 онд батлагдлаа. Энэхүү хуулийг батлах үйл явц иргэний нийгмийн болон бусад гадаад хүчин зүйлийн хүчтэй шахалт, шууд хяналт, нөлөөн дор өрнөсөн юм. Ийнхүү 15 гаруй жилийн туршид яригдаж ирсэн Авилгын эсрэг хууль хэрэгжих болсноор Монгол орны баялгийг иргэд бидний өмнөөс захиран зарцуулж байдаг төрийн өндөр албан тушаалтнууд анх удаа хөрөнгө, орлогоо олон нийтэд ил тод мэдээлэхээр боллоо. Одоо гагцхүү иргэд бид идэвхитэй байж эрх баригчид нийтийн баялгийг хувьдаа болоод намдаа завших, ойр дотныхондоо зувчуулах явдлыг таслан

зогсоох л үлдэж байна. Түүнчлэн авилгатай тэмцэх зорилгын хүрээнд Нээлттэй Нийгэм Форум иргэний нийгмийн байгууллагуудын төрд тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулахад дэмжлэг болгон арга зүйн болоод санхүүгийн туслалцаа үзүүлсээр ирлээ.

Улсын төсвийн орлого урьд байгаагүйгээр нэмэгдэх үндсэн эх үүсвэр болсон уул уурхайн салбар 2006 онд аанай л олны анхаарлын төвд байлаа. Иргэд, олон нийтийн хөдөлгөөнүүдийн санаачилга, тэмцлийн үр дүнд Монголын парламент “Ашигт малтмалын тухай” хуулийг шинэчлэн баталж, уул уурхайн хөгжлийн ашиг шимийг монголчууд шударгаар хүртэх боломж нээгдлээ. Үүний үр дүнд хөрөнгө оруулагчид, Монголын олон нийтийн эрх ашиг харилцан дүйцэхүйц эрх зүйн шинэ орчин бүрэлдэж эхэлж байна. Уул уурхайн салбар улс орны хөгжилд хувь нэмрээ оруулахад түлхэц болгох үүднээс ННФ олон нийтийг бодитой мэдээллээр хангахад түлхүү анхаарч нээлттэй ярилцлага хэлэлцүүлгүүдийг өрнүүлсний зэрэгцээ салбарын зарим асуудлаар төр засагт зориулан тодорхой зөвлөмж боловсруулсан болно. Уул уурхай, ашигт малтмалын салбараас олох орлогыг шударгаар авах нөхцөл бүрдсэнээр хараахан тайвширч болохгүй юм. Цаашлаад

хэдий хэрийн орлого олж байгаагаа Монголын олон нийт мэддэг, түүндээ бодитой хяналт тавьж чаддаг, улс орныхоо хөгжил, эрх ашигт нийцүүлэн зүй зохистой зарцуулдаг байх ёстой билээ. Чухам үүнд л манай улсын нэгдэн орсон Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга чухал ач тустай арга хэрэгсэл байна хэмээн бид үздэг. Иймээс энэхүү санаачилгыг бодит ажил хэрэг болгохын төлөө Нээлттэй Нийгэм Форум цаашид өөрийн хүч чадлаа дайчлан ажиллах болно.

Монголд хүний эрх, эрх чөлөөг хангасан шударга нийгмийг бүрдүүлэх үйл хэрэгт ННФ ямагт анхаарч, хүчин чармайлт тавьсаар ирсэн билээ. Ийм хүчин чармайлтын нэг тодорхой жишээ бол төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрх зүйн туслалцаа юм. Хэрэг түвэгт холбогдсон төлбөрийн чадваргүй иргэд хүний эрхээ эдэлж эрх зүйн туслалцаа авдаг тогтолцоог бий болгох зорилгоор хэрэгжүүлсэн бидний төсөл үр дүнгээ өгч 2006 онд Засгийн Газраас “Төлбөрийн чадваргүй иргэдэд

хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан баталжээ.

Улс орны хөгжлийн амин сүнс болсон орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор Нээлттэй Нийгэм Форум дөрвөн аймгийн дөрвөн суманд төр, бизнес, иргэдийн оролцоотойгоор орон нутгийн эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлал, төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга замыг боловсруулахад нь туслалцаа үзүүлж эхэллээ.

Энэ мэт хийж бүтээсэн, бүтээхийг оролдон зорьж яваа үйл хэргээ Та бүхний өмнө толилуулан буй энэхүү тайланд хураангуйлан багтаасан бөгөөд сонирхогч авхай үзэн танилцаад бидэнтэй хамтарч бодол төрөн хөдөлбөл баярлан хүлээн авах болно.

## **Нээлттэй Нийгэм Форумын гүйцэтгэх захирал**

### **П.Эрдэнэжаргал**



# Засаглал

НЭЭЛТЭЙ НИЙГЭМ ФОРУМ  
**2006**  
ЖИЛИЙН ТАЙЛАН



## ■ ИЛ ТОД БАЙДАЛ

Олон жил яригдсан “Авилгын эсрэг хууль” 2006 онд батлагдан гарлаа. Энэхүү хуулиар Монголд анх удаа Авилгатай тэмцэх байгууллагыг байгуулахаар болж, түүний чиг үүргийг тодорхойлсон юм. Нээлттэй Нийгэм Форум авилгын эсрэг хуулийг батлуулах явдалд байнга анхаарлаа хандуулж ирсэн бөгөөд хуулийн төслийг хэлэлцэх явцад гадаад, дотоодын экспертүүдээр санал зөвлөмж боловсруулах ажлыг зохион байгуулж төслийг боловсруулах ажлын хэсэгт хүргүүлжээ. Энэхүү санал зөвлөмжийн гол санаа нь уг хуулинд ашиг сонирхлын зөрчил болон хөрөнгө орлогын мэдүүлгийн талаарх зохицуулалтыг бий болгоход

чиглэж байлаа. Сонирхлын зөрчлийн асуудал нь Монголын хувьд нэлээд газар авч буй хэдий ч харьцангуй шинэ ойлголт учраас хуулиар сайн тодорхойлж зохицуулж чадвал авилгаас урьдчилан сэргийлэх гол нөхцөл болох юм. Хуулийн төсөлд хөрөнгө, орлогын мэдүүлгийг хувь хүний нууцад хамааруулан “Хувь хүний нууцын тухай” хуулиар зохицуулан зөвхөн нийт хөрөнгө болон орлогын мөнгөн дүнгийн хэмжээг олон нийтэд нээлттэй байхаар заасан байсныг өөрчлөх, тухайлбал, хөрөнгө орлогын мэдүүлгийг бүхэлд нь олон нийтэд хүртээмжтэй хэлбэрээр хэвлэх, вэбсайтад байрлуулах зэргээр ил тод байдлыг хангах тодорхой зохицуулалт оруулахыг санал болгосон

нь хуулинд тусгалаа олсон байна. Эдгээр санал зөвлөмжийг гаргахдаа Естони, Литва, Латви зэрэг авилгыг бууруулах асуудлаар тодорхой ахиц дэвшил гаргаж буй орнуудын тэргүүн туршлага дээр үндэслэсэн болно.

Ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг улам гүнзгийрүүлэн судлах зорилгоор ННФ-ын 2006 оны бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд Сонгогчдын Боловсрол Төвийн ажилтан С.Оюунтуяа судалгаа хийхээр боллоо. Судалгааны хүрээнд сонирхлын зөрчлийн түгээмэл хэлбэрүүд, түлхүү гардаг салбарууд, нөлөөлж буй нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн хүчин зүйлсийг тодорхойлж цаашид таслан зогсоох арга хэмжээний талаар бодлогын зөвлөмж гаргана. Энэ нь сонирхлын зөрчлийн асуудлыг Монголын хувьд гүнзгийрүүлэн авч үзэж буй анхны судалгаа болох юм.

Нээлттэй Нийгэм Форум төрийн ил тод байдлын асуудлыг хөндсөн, олон нийтийн оролцоотой анхны форумыг “Төрийн ил тод байдал: Нийгмийн баялгийн хуваарилалт” сэдвээр 2006 оны 12 дугаар сарын 7-нд зохион байгууллаа. Энэхүү форум нь ил тод байдлыг хангах чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааг үнэлэн дүгнэж, оршиж буй бэрхшээл хүндрэлийг тодорхойлж, даван туулах арга замыг талууд хамтран хэлэлцэх зорилготой байлаа. Форумд төр, иргэний нийгэм,

хувийн хэвшлийн 180 гаруй хүн оролцсон бөгөөд тэдний гуравны нэг нь хөдөө орон нутгийн төлөөлөгчид байлаа.

Форумаар нийгмийн баялгийн хуваарилалтын тулгамдсан салбар болох улсын төсөв, газар олголт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал болон хууль эрх зүйн орчин зэрэг асуудлыг авч хэлэлцсэн юм. Эдгээр салбарыг хариуцсан төрийн байгууллага, иргэний нийгмийн төлөөлөгчид тулгарч буй асуудлуудын талаар өөр өөрсдийн байр сууринаас илтгэл тавин, хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд салбар хуралдаан бүрээс цаашид авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаар зөвлөмж гаргалаа.

Ил тод байдлыг хангах хууль эрх зүйн орчин сэдэвт салбар хуралдаанаар хууль тогтоомжийн зохицуулалтын өнөөгийн байдал, мэдээллээр үйлчлэх төрийн үүрэг, хууль тогтоох үйл ажиллагааны ил тод байдал зэрэг асуудлаар илтгэл тавьж, санал шүүмжлэл өрнүүлэв. Оролцогчид төрийн ил тод байдлын эрх зүйн зохицуулалт тунхагийн шинжтэй, хэрэгжүүлэх механизм нь тодорхой бус байгаагийн зэрэгцээ төрийн байгууллагууд иргэдэд хэрэгцээтэй мэдээллийг нь хүргэхээс илүүтэй өөрийн сурталчилгааг анхаардаг талаар тодорхой жишээ баримтаар дурдав. Цаашид авах арга хэмжээний хувьд эрх зүйн зохицуулалтыг сайжруулах,

төрөөс иргэдэд хүргэх мэдээллийн хүртээмжийг дээшлүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэж батлах болон хуулийг хэрэгжүүлэх шатанд иргэдийн оролцоог хангах талаар тодорхой санал зөвлөмжийг дэвшүүллээ.

Улсын төсвийн ил тод байдлын салбар хуралдаанаар иргэдийг төсвийн мэдээллээр хангахад төрийн хүлээх үүрэг хариуцлага, төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны тухай мэдээллийн олдоц, хэрэгцээ зэрэг асуудлыг хэлэлцэж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд оролцох, хяналт тавих иргэдийн эрх хэрэгждэггүй, төсвийн гүйцэтгэлийг олон нийтэд тайлагнах, хариуцлага хүлээх тогтолцоо огт байхгүй талаар шүүмжлэн ярилцлаа. Мэдээлэл эрх тэгш, тэнцвэртэй хүрдэггүйгээс төрийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл явц шударга бус явагдах, төсвийн зарцуулалт үр ашиггүй байх, авилга бий болох нөхцлийг бүрдүүлж байгааг онцлов.

Газар олголтын ил тод байдлын салбар хуралдаанаар газрын зөрчил, маргаан

газар авч буй гол шалтгаан нь газар олгох үйл явц ил тод бус, олон нийтийн эрх ашгийг үл харгалздаг, газрын зөрчил, маргааныг оновчтой хэлбэрээр шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт, механизм дутагдалтай талаар хэлэлцсэн байна.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын талаарх хуралдаанд байгалийн баялгийн үр шимийг иргэд жигд хүртэх, тэдний эрх ашигт учруулах хохирол, байгаль орчны доройтол зэрэг сөрөг үзэгдлийг зөв зүйтэй шийдвэрлэхэд иргэдийн оролцоо зайлшгүй шаардлагатай байгаа тухай болон лиценз, гэрээ хэлэлцээр, татвар төлбөртэй холбоотой мэдээлэл ил тод бус байгаа нь авилга үүсэх нөхцлийг бүрдүүлж, улмаар хөрөнгө оруулалтын орчинд сөрөг нөлөө үзүүлж болохыг оролцогчид сэрэмжлүүлж тодорхой зөвлөмжүүдийг гарган олон нийт болон шийдвэр гаргагчдад сонордуулсан юм.

Нээлтэй Нийгэм Форум төр, иргэний нийгэм, бизнесийнхэн ил тод байдлын асуудлаар уулзаж ярилцах нэг талбар болгож энэхүү форумыг цаашид жил бүр тогтмол зохион байгуулахаар боллоо.





## ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Нээлттэй Нийгэм Форум 2006 онд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг дэмжих зорилгынхоо хүрээнд Монголын үндэсний радио, телевизийг Олон Нийтийн Радио, Телевиз (ОНРТ) болгоход чиглэсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжсэн юм. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөрийгөө зохицуулах механизмийг бий болгож хөгжүүлэх, сэтгүүлчдийн мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Монголын үндэсний радио, телевизийг ОНРТ болгох шилжилтийг дэмжихэд ННФ анхнаасаа шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд 2006 онд

Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевизийн (МҮОНРТ) удирдлагууд, мэргэжилтнүүд, Үндэсний зөвлөлийн гишүүдийг оролцуулсан цуврал уулзалт ярилцлагыг зохион байгууллаа. Тухайлбал, Швейцарь улсын “Хэвлэл Мэдээлэл ба Нийгэм” сангаас сургагч багш урьж ирүүлэн сургалт явуулав. Швейцарийн Өргөн Нэвтрүүлгийн Корпорацид ерөнхий захирлаар есөн жил ажилласан ноён Антонио Рива мэдээлэл болон агуулгын чанар, ёс зүй, хараат бус байдал, удирдлагын ил тод байдал, үзэгч сонсогчидтой тогтоох харилцаа зэрэг өргөн нэвтрүүлэгт тулгардаг гол асуудлуудын талаар Монголын

сэтгүүлчдэд тайлбарлаж өгсний зэрэгцээ чанарын удирдлагын системүүдийн талаарх заавруудыг сургалтдаа ашигласан юм. Энэхүү чанарын удирдлагын системийн тухай зааврыг сонирхож байгаагаа хэвлэл мэдээллийн бусад байгууллага илэрхийлсэн учраас ННФ түүнийг орчуулан хэвлэж, хэвлэл мэдээллийн байгууллагууд, өдөр тутмын болон бусад сонин хэвлэл, телевиз, хэвлэл мэдээллийн салбарын холбоодод түгээлээ. Мөн эксперт багш маань ОНРТ-ийн удирдлагууд, Үндэсний зөвлөлийн гишүүдэд зориулж ОНРТ-ийн хуулийн дагуу боловсруулах ёстой Ерөнхий захирлын гэрээ, ёс зүйн дүрэм зэрэг баримт бичгийн талаар зөвлөгөө өгсөн болно.

ННФ ОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүдийг нэр дэвшүүлсэн ТББ-уудтай хамтран ОНРТ-д шилжих шилжилтийн явцын талаар Үндэсний зөвлөлийн гишүүдийг оролцуулсан уулзалт зохион байгуулав. Энэхүү уулзалтыг ТББ-уудын санаачилгаар хийсэн бөгөөд уулзалтын үр дүнд үйл ажиллагаа, ахиц дэвшлийнхээ талаар олон нийтэд мэдээлэх зорилготой уулзалтыг Үндэсний зөвлөлийн гишүүд цаашид өөрсдөө санаачилан зохион байгуулахаар тохирсон байна.

Монголд хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сэтгүүлчид мэргэжлийн хувьд өсөн дэвжих боломжийг бүрдүүлэх үүднээс Нээлтэй Нийгэм Форум Нью

Йорк дахь Бодлогын Хэлэлцүүлгийг Дэмжих Санаачилга (БХДС буюу IPD) байгууллагатай хамтран эдийн засаг, хөгжлийн асуудлаар бичдэг сэтгүүлчдийн дунд “Шилдэг бичлэг”-ийн уралдааныг явуулж шагнал олгов. Энэхүү шагнал нь Монгол дахь уул уурхай, ядуурлыг бууруулах, төсвийн шинжилгээ гэх мэт эдийн засаг, нийгмийн хөгжилтэй холбоотой асуудлыг хөндөн бичих урам зоригийг сэтгүүлчдэд өгөхөд тус нэмэр болсон гэж үзэж байна. Цаашид энэхүү шагналт уралдааныг жил бүр уламжлал болгон явуулахаар төлөвлөж байна. Түүнчлэн уул уурхайн сэдвээр бичих гарын авлага болох ННХ-ийн Орлогын Ажиглагч, БХДС зэрэг байгууллагаас гаргасан “Газрын тосны тухай бичихүй” номыг монгол хэлнээ орчуулан хэвлэж сэтгүүлчдэд түгээлээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөрийн зохицуулалтын байгууллагыг бий болох үүднээс ННФ-ын санхүүжилтээр Глоб интернэшнл (ГИ) ТББ-ын хэрэгжүүлсэн туршилтын төслийн хүрээнд Хэвлэлийн цэцийн ёс зүйн дүрмийг боловсруулж, ийм байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг бодитойгоор бий болгох талаар Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлтэй хамтран ажиллалаа. Цаашид иргэний нийгэм, олон нийт, мэргэжлийн сэтгүүлчдийн байгууллагаас дэмжлэг авах замаар Хэвлэлийн зөвлөл байгуулах, сэтгүүлчдийн ёс зүйн дүрмийг албан ёсоор батлах явдлыг дэмжих алхмууд хийхийг зорьж буй болно.

Мөн Глоб Интернэшнл байгууллагын “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” төслийг Лондон дахь Хэвлэл Мэдээллийн Хэрэгслийн Сүлжээ хөтөлбөртэй хамтран дэмжин ажиллаж байна. 12 сарын хугацаатай хэрэгжиж буй энэхүү төсөл нь Монгол дахь үзэл бодлын чөлөөт байдлын илэрхийлэлд мониторинг хийх чадавхийг бэхжүүлэх зорилготой бөгөөд Үзэл Бодлоо Илэрхийлэх Эрх Чөлөөний Олон Улсын Солилцоо (IFEX) болон Москвад төвтэй Хүнд Нөхцөлд буй Сэтгүүлчдийн Төлөө Төв (CJES) байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрхийн зөрчилд 2006 оны нэгдүгээр сараас эхлэн бодитойгоор хяналт шинжилгээ хийж эхэлсэн бөгөөд одоогоор 26 зөрчлийг тогтоогоод байна. Энэ талаарх тайлан гаргах ажилд IFEX зөвлөгөө өгч ажилласан ба CJES-ээр дамжуулан анхны сэрэмжлүүлэг тарааснаас хойш уг ажлын чанар нэлээд дээшлээд байна. 2006 оны хоёрдугаар сард Глоб Интернэшнл байгууллага IFEX-н гишүүн болсон бөгөөд IFEX-ийн үзэл бодлын чөлөөт илэрхийлэх сүлжээний гишүүн бусад байгууллагатай холбоо тогтоосон байна. Түүнчлэн мэргэжлийн

хуульчдаар сэтгүүлчдэд зориулсан эрх зүйн зөвлөгөөг тогтмол өгөх боллоо.

2006 оны нэгдүгээр сараас хойш энэхүү төслийн хүрээнд сэтгүүлчид, хуульчдад зориулсан таниулах уулзалт, дугуй ширээний ярилцлага, хяналт шинжилгээний үр дүнг мэдээлэх хэвлэлийн бага хурлуудыг зохион байгуулжээ. Ийнхүү үзэл бодлоо илэрхийлэх эрхийн зөрчлийн талаарх мэдлэг мэдээллийг нийтдээ хэвлэл мэдээллийн 48 хэрэгслийг төлөөлсөн 70 гаруй сэтгүүлчдэд олгосон байна. Мөн “Цензурын эсрэг!” сэдэвт дугуй ширээний ярилцлагаар сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөгчдөд цензурын мөн чанар, төрлүүдийн талаар мэдлэг олгосон бөгөөд мэдээллийг сонин хэвлэлээр дамжуулан түгээлээ.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх олон улсын стандартуудын талаар эрх мэдэлтнүүдэд тодорхой ойлголт төрүүлэхийн зэрэгцээ сэтгүүлчид өөрсдийн эрхээ мэдэж, тэр нь зөрчигдвөл туслах байгууллага бий гэдэгт итгэдэг болох нь энэ төслийн нэг гол үр нөлөө байх юм.



## НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД ТӨСӨВ

Эдийн засгийн өсөлт өндөр, төсвийн орлого, зарлагын хэмжээ үлэмж нэмэгдсэн энэ үед төсвийн мэдээлэл ил тод байж, төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоог бүрдүүлэх, нэн ялангуяа тэдний зүгээс төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтыг хянах явдал улам бүр чухал болж байна. Хэдийгээр төсвийн мэдээлэл, үйл явц олон талаар хаалттай хэвээр байгаа ч 2006 онд зарим нэгэн ахиц дэвшил гарлаа. Тухайлбал, Засгийн газраас УИХ-д өргөн барьдаг төсвийн төсөл анх удаагаа УИХ-аар хэлэлцэх үе шатанд олон нийтэд ил болов. Нээлтэй Нийгэм Форумын хувьд 2006 онд иргэний нийгмийн зүгээс төсвийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн

шийдвэрүүдийн талаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүллээ. Чингэхдээ төсвийн мэдээллийг иргэдэд хүргэх тал дээр улам анхаарч ажилласан бөгөөд АНУ-д төвтэй Олон Улсын Төсвийн Төсөл (ОУТТ)-тэй хамтран хэд хэдэн төсөл хэрэгжүүллээ.

Төсвийн талаар дүн шинжилгээ хийх үр чадварыг олгох олон улсын сургалт семинарыг зохион байгуулж, Монгол, Армени, Азербайжан, Казахстан, Кыргызстан, Пакистан зэрэг орны 21 оролцогч хамрагдсан нь харьцуулалт хийх, үзэл бодол, туршлагаа солилцох боломжийг олголоо. Энэ бол иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан анхны сургалт бөгөөд ОУТТ-ийн хоёр багш удирдан явуулж, бүс нутгийн хамтын

ажиллагааны үндэс суурийг тавив. Сургалтад оролцсон ННФ-ын хоёр ажилтан цаашид ийм сургалтыг орон нутгийн төвшинд гүйцэтгэх боломжтой болсон байна.

ОУТТ-өөс гаргадаг “Олон улсын төсвийн санал асуулга” судалгааг ННФ 2006 онд үргэлжлүүлэн хийв. Дэлхийн 59 улс орныг хамарсан энэхүү харьцуулсан судалгаа нь Нээлттэй Төсвийн Индекс-т Монгол Улс ямар байр эзэлж буйг тодорхойлсон юм. Харамсалтай нь Монгол Улс “Иргэдээ мэдээллээр хангалтгүй хэмжээнд хангадаг” улс орны тоонд багтаж, дээрх индексийн сүүлийн 10 улс оронтой нэг эгнээнд явна. Энэ индекст эзлэх байр сууриа манай улс цаашид дээшлүүлэх тал дээр ахиц дэвшил гарч байгаа эсэхийг ННФ ажигласаар байх юм. Ийм ахиц дэвшил гарснаар иргэд мэдээлэл хүртэх боломжтой болж, төсвийн үйл явцад оролцож, төсвийн гүйцэтгэлд мониторинг хийн эцсийн дүндээ төр, засгийн хариуцлагыг нэмэгдүүлэх юм. Судалгааны дүнг Монголын олон нийтэд хүргэх ажлыг өргөн цар хүрээтэйгээр гүйцэтгэж, иргэд, холбогдох албан тушаалтнуудын санал бодлыг авсан болно.

Дээрх судалгааны дүнтэй холбоотойгоор Сангийн Яам төсвийн мэдээллийг олон нийтэд илүү хүртээмжтэй болгох үүднээс “Ил тод төсөв” нэртэй вэб хуудсыг нээх ажлыг ННФ-аас санхүүжүүлж дэмжлэг үзүүлэв. [www.iltod.gov.mn](http://www.iltod.gov.mn) хаягтай уг вэб хуудсанд төсвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг байнга тавихаар тохиролцсон

бөгөөд 2007 оны төсвийн дэлгэрэнгүй мэдээлэл тавигдсан нь мэдээллийг нээлттэй болгох чухал алхам боллоо.

Орон нутгийн төвшинд төсвийн мэдээллийг илүү нээлттэй болгох, иргэдийн оролцоог хангах үүднээс сум, орон нутгийн иргэдэд зориулсан төсвийн зурагт хуудсыг агуулга, бүтцийн хувьд бэлтгэсэн бөгөөд цаашид энэ зурагт хуудсыг байршуулж, үүнтэй холбогдуулан иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг хийхээр төлөвлөж байна.

Түүнчлэн төсөвт дүн шинжилгээ хийх загвар маягыг экспертүүдийн дэмжлэгтэйгээр бэлтгэсэн бөгөөд иргэний нийгмийн дөрвөн байгууллагын судлаачдад 2007 оны төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх боломжийг ННФ-ын зүгээс олголоо. Эдгээр дүн шинжилгээнд үндэслэсэн санал зөвлөмжийг бодлого боловсруулагчид, иргэд оролцсон нээлттэй хэлэлцүүлгээр хэлэлцэж, олон нийтийн хүртээл болгов. Дүн шинжилгээнүүд нь хөрөнгө оруулалтын бодлого, төсвийн орлого, зарлагын дүн шинжилгээнээс гадна төсвийн хүйсийн мэдрэмжийг судалснаараа онцлог болсон юм.

Өмнөх онд эхлүүлсэн боловсролын салбарын төсвийн судалгааг ННФ эцэслэн гүйцэтгэж үр дүнг нь олон нийтэд танилцууллаа.

Монголын боловсролын салбарын төсвийн зарцуулалтын судалгааны анхдагч тайлан 2005 онд гарч, 2006 онд Дэлхийн Банкны мэргэжилтнүүд нарийвчилан боловсруулж эцэслэн хэвлэлээ.

## **Боловсролын салбарын төсвийн зарцуулалтын судалгааны үр дүнгээс**

Төсвийн зарцуулалтын энэ судалгаа нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль (ТБУСХ) хэрэгжиж эхэлснээс хойш хийсэн анхны судалгаа бөгөөд сургууль, аймаг дүүрэг, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам гэсэн гурван төвшинд цуглараад байгаа төсвийн холбогдолтой дүн мэдээг харьцуулан судалсан юм. Судалгааны үр дүнд 21 аймаг, нийслэлийн дүүргийн 118 сургуулийн төсөв, санхүүгийн холбогдолтой дүн мэдээнээс гадна төсөв төлөвлөх, батлах, гүйцэтгэх үйл явцыг бүхэлд нь харуулсан мэдээллийн сан бүрджээ.

- Судалгаанаас үзэхэд төсвийн хөрөнгийг зориулалтын бус зорилгод дахин хуваарилах, төсвийн санхүүжилт хоцрох, алга болох зэрэг дутагдал алга болж, батлагдсан төсөв сургуульд бүрэн хэмжээгээр очдог болсон нь хуулиар зохицуулсан төсвийн сахилга бат бодитойгоор хэрэгжиж байна. Харин төсвийн эрх мэдлийг тараан хуваарилах, харилцан хяналтыг улам нэмэгдүүлэх тухай хуулийн өөр нэгэн гол санаа Улаанбаатарт хэрэгжихгүй байгаа нь ажиглагдав. Төсөв батлах чиг үүргийг БСШУЯ, түүний харьяа аймаг, нийслэлийн Боловсрол Соёлын газарт, харин төсвийн санхүүжилтийг олгох чиг үүргийг Сангийн Яамны харьяа Төрийн санд даалгахаар хуульчилсан боловч Улаанбаатарт дээрх хоёр чиг үүргийг дүүргийн Төрийн сан дангаараа гүйцэтгэж байна. Иймээс Улаанбаатар хотын хувьд хуульд заасан харилцан хяналтын дээрх механизмыг зохих ёсоор нь хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Сургуулийг нэг сурагчид ногдох хувьсах зардлаар санхүүжүүлэх болсон нь жигд сайн үр дүнтэй арга болж чадахгүй байна. Ялангуяа элсэлт цөөрсөн хөдөөгийн жижиг сургууль, түүний дотор нийгмийн үйлчилгээг алслагдсан хөдөө орон нутагт хүргэх ажилд хувь нэмрээ оруулж байгаа багийн бага сургуулийн хэрэгцээнд энэ аргачлал нь төдийлөн нийцэхгүй байгааг анхаарах цаг болжээ.
- Багшийн ажлын үнэлгээ, урамшууллын хувьд юуны өмнө сайн ажиллаж байгаа нэгийг нь урамшуулах боловсон хүчний бодлогын нэг хэрэгсэл болсон гүйцэтгэлийн урамшуулал, үүнтэй холбоотойгоор Үр дүнгийн гэрээний асуудлыг бусад улс орны туршлагатай харьцуулан судалж, үр өгөөжтэйгөөр ашиглах стратеги боловсруулах хэрэгтэй байна.

Судалгааны тайланд багтсан зөвлөмжүүдийг БСШУЯ, СЯ, боловсролын асуудлаар ажилладаг төрийн бус байгууллага, боловсролын салбарын мэргэжилтнүүдэд танилцуулан хэлэлцүүлэг хийсний зэрэгцээ БСШУЯ-ны Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн ажилтнуудад танилцуулсан нь тодорхой үр дүнд хүрч байна.

ННФ-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар болсон “Төрийн ил тод байдал” үндэсний форумын үеэр төсвийн ил тод байдлын асуудлыг онцгойлон авч үзлээ. Форумд Сангийн яам төсвийн ил тод байдал, оролцоог хангах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээ танилцуулсан бол ННФ Нээлттэй төсвийн индексийг танилцуулж, мөн ННФ-ын судлаач төсвийн мөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах үйл явцад гарч буй догогдлуудыг судалгааны үндсэн дээр дэлгэн танилцуулав. Иргэний нийгмийнхэн, төв болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагын төлөөлөгчид, судлаачид, мөн бизнесийн хүрээнийхэн төсвийн ил тод байдалтай холбоотой хүндрэл бэрхшээлийг арилгахын тулд авах ёстой арга хэмжээний талаар санал солилцож, улмаар нэгдсэн санал зөвлөмж гаргаж, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэлээ.

ННФ олон улсын төвшинд иргэний нийгмийн зүгээс хийж буй төсвийн үйл

ажиллагааны ололт амжилт, сургамжийн талаар хийсэн олон улсын уулзалтад оролцож, өөрсдийн туршлагыг хуваалцлаа. Дэлхийн өнцөг булан бүрт иргэний нийгмийн байгууллагуудын төсвийн үйл явцад оролцоход нь тулгарч буй хүндрэлийг авч үзснээрээ уг уулзалт онцгой ач холбогдолтой байв.

Төр, засгийн янз бүрийн төвшинд төсвийн зарцуулалт ямар байгаад мониторинг хийх зорилгоор гурван ТББ-д ННФ тэтгэлэг олгосон. Эдгээрээс хоёр нь орон нутгийн төвшинд, нэг нь Засгийн газрын хэмжээнд мониторинг хийв.

Дээрх үйл ажиллагаанууд болон иргэний нийгмийн шахалт, шаардлагын дүнд 2006 онд төсвийн үйл явцын талаарх мэдээллийг олон нийт хүртэх боломж тодорхой хэмжээгээр нэмэгдсэн гэж ННФ дүгнэж байна. Мөн төсвийг хэлэлцэх явцад хэвлэл мэдээллийн хэрэгслүүд анхаарлаа хандуулах байдал сайжирсан ч төсвийн талаарх тодорхой шийдвэрт иргэний нийгмийн бүлэглэлүүд нөлөөлөх чадвараа илүү хөгжүүлэх шаардлагатай байна.

ННФ нь төсвийн тогтвортой байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх, улстөрийн нөлөөллийг хязгаарлах тал дээр цаашдын судалгаа, үйл ажиллагаагаа төвлөрүүлэхээр зорьж байгаа болно.

### Төсвийн мониторингуудын зарим үр дүнгээс

- Байгаль орчныг хамгаалах сангийн зарцуулалтад хийх мониторинг нь Байгаль орчны яамтай холбоотой тусгай хэрэгцээний сангийн зарцуулалтын талаар дүн шинжилгээ хийх цөөн оролдлогын нэг байв. Энэ сангийн хөрөнгө хэдийгээр олон нийтийн мөнгөөр бүрддэг ч яамны дээд шатны албан тушаалтнууд удирдан зарцуулдаг.
- Сумын төсвийн зарцуулалтын талаар орон нутгийн төрийн бус байгууллага мониторинг хийснээр төсвийг батлах, зарцуулах, хянах үйл явцад орон нутгийн иргэд оролцох, хяналт тавих боломж байхгүй байгааг баримтаар нотлон харуулж, энэ төсөв нь орон нутгийн хөгжилд нэмэрлэхээсээ илүүтэй зардлын шинжтэйг байгааг шүүмжилжээ.
- “Төсвийн хүү торгуулийн орлогын бүрдүүлэлтийн мониторинг” төслийн хүрээнд төсвийн татварын бус орлогын нэг төрөл болох хүү торгуулийн орлогыг сонгон авч мониторинг хийсэн болно. Мониторингийн үр дүнд хүү торгуулийн орлогыг бүрдүүлэх төлөвлөгөө гаргаж, албан тушаалтын ажлыг дүгнэхдээ түүнийг харгалзаж байгаа нь хүний эрхийн зөрчлийн үндэс болж буйг тогтоосон байна. Улмаар төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй албан тушаалтнууд жижиг бизнес эрхлэгчдэд дарамт учруулж, үүнийг засч залруулах, хяналт тавих дотоод болон иргэдийн оролцоотой гадаад механизм байхгүй байна.



## ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОЛОН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН МОНИТОРИНГ

Ардчилсан нийгмийн оршин тогтнох үндэс суурь нь ардчиллын зарчмуудад тулгуурлан үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод явуулдаг, хариуцлагатай төр байдаг. Ийм төр бодитой бүрэлдэхэд саад болж буй болон цаашид учирч болох бэрхшээл, алдаа дутагдлыг соргоогоор хянан шүүмжилж, засч залруулах талаар хүч чармайлт гаргах нь иргэний нийгмийн байгууллагуудын хүлээх ёстой чухал үүрэг юм.

Монгол Улсад иргэний нийгмийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болсон төрийн бус байгууллагууд /ТББ/ сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, үйл ажиллагаа нь өргөжин тэлсээр ирсэн боловч иргэний нийгмийн гүйцэтгэвэл зохих үндсэн үүрэг болох төр, засгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих тал дээр ТББ-уудын санаачилга оролцоо харьцангуй бага байсаар иржээ. Монгол орон ардчилсан хөгжлийн замыг сонгосноос хойш яригдсаар ирсэн ил тод байдлыг

жинхэнэ утгаар хангаж, дээр дооргүй газар авсан гэх авилгаас ангижрахад энэхүү хөндлөнгийн хяналт нэн чухал ач холбогдолтой юм. Иймд Нээлттэй Нийгэм форум энэ талаарх ТББ-уудын чадавхи, нөөц бололцоог дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2005 оноос эхлэн төрийн үйлчилгээний мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж ирлээ.

Уг тэтгэлэгт хөтөлбөрийн эхлэлийг тавьсан 2005 онд 15 төрийн бус байгууллага төрийн хэд хэдэн чиглэлийн үйлчилгээнд мониторинг хийсэн бөгөөд тэдний гүйцэтгэсэн ажлын тайланг эмхэтгэн олон нийтийн хүртээл болгоод байна. Энэхүү эмхэтгэлд халамжийн үйлчилгээ, шүүх, гааль, газар болон лиценз олголтод хийсэн мониторингийн тайлангуудыг хураангуйлан оруулсан бөгөөд эдгээр үйлчилгээнд гарч байгаа алдаа дутагдал, түүний учир шалтгааныг тайлбарлан засч залруулах талаар үнэтэй зөвлөмж боловсруулсан болно.

## Мониторингийн зарим үр дүнгээс

2005 онд ННФ-ын мониторингийн хөтөлбөрийн тэтгэлэгээр “Зориг Сан” Замын-Үүд, Алтанбулаг боомтын гаалийн албад болон Улаанбаатар хотын Толгойтын гүнийн гаалийн албаны үйл ажиллагаанд мониторинг хийв.

Мониторингоор Гаалийн байгууллага нь улсын төсвийн 40 гаруй хувийг гааль, НӨАТ, зарим нэрийн барааны онцгой албан татвараар бүрдүүлж байгаа нь өнгөцхөн харахад их тоон үзүүлэлт мэт боловч хураах ёстой татварынхаа дөнгөж 50-60 хувийг хурааж, бусдыг нь худалдааны луйвар, татварын булхай, авилга хээл хахуулийн замаар алддаг байна гэсэн дүгнэлтийг хийжээ.

Гаалийн байгууллага дахь боловсон хүчний алдаа завхрал, хүнд суртлыг арилгаж, авилга дагуулсан элдэв хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгаж чадвал улсын төсөвт орох мөнгийг наад зах нь 2-3 дахин нэмэгдүүлэх боломжтой гэсэн тооцоог хийсэн байна.

2006 онд мониторингийн хөтөлбөрийн сэдвийн хамрах цар хүрээг улам өргөжүүлэн төрийн үйлчилгээнээс гадна бодлогын хэрэгжилтийн мониторингийн хөтөлбөр зарлалаа. Тэтгэлэгт хөтөлбөрийг хоёр удаа нээлттэй зарлаж сонгон шалгаруулахад нийтдээ 78 байгууллага төслийн саналаа ирүүлснээс тодорхой шалгуурт үндэслэн 21 ТББ-ыг сонгож мониторингийн үйл ажиллагаанд нь тэтгэлэг олгов.

Тухайлбал, Айвуун ТББ хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай дансны үйлчилгээнд, Тусламжийн

Тэргэнцэр Сан засаг захиргаа, соёл, олон нийтийн байгууллагуудад тэргэнцэртэй иргэд нэвтрэх боломж нөхцөл, тэргэнцэрийн зам барих нормативийн хэрэгжилтэд, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн Баянхонгор дахь салбар орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хяналт тавих иргэний нийгмийн оролцооны байдалд, Хуульч Эмэгтэйчүүдийн Холбооны Завхан дахь салбар төрийн албанд ажилтан сонгон шалгаруулах үйл ажиллагаанд, Өмнөговь аймгийн Амжилтын Томьёо ТББ цэцэрлэгийн хүүхдийн хоолны хангамж үйлчилгээнд,

Либераль Эмэгтэйчүүдийн Оюуны Сангийн Өмнөговь аймгийн салбар зөвлөл аймгийнхаа Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаарх 16 заалтын хэрэгжилтэд, Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөний Өмнөговь дахь салбар Засгийн газрын “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэд, Хөдөлмөрийн Эрх зүй Судлаачдын Холбоо Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 67-р зүйлийн гүйцэтгэлд, Либераль эмэгтэйчүүдийн Оюуны Сан дунд сургуулийн сурах бичгийн хүртээмжийн асуудалд, Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөний Дарханы салбар сурагчдаас авч буй хууль бус төлбөр хураамжийн асуудалд, Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн “Улстөрийн намын тухай” хуулийн санхүүжилтийн талаарх заалтуудын хэрэгжилтэд, Нийгмийн Халамж Хамтын Ажиллагааны Сан болон Багануур дүүргийн CEDAW-ын салбар зөвлөл нийгмийн халамжийн үйлчилгээнд, Эрүүл Мэндийн Боловсролын Зөвлөгөө, Мэдээллийн Төв “Архидан согтуурахтай

тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт болон түүнд хянал тавих төрийн үйл ажиллагаанд, Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо шатахуун түгээх станц эрхлэх зөвшөөрөл олгох төрийн үйлчилгээнд, Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Чөлөөт Үйлдвэрчний Эвлэл Хөдөлмөрийн хуулийн 111-р зүйлийн хэрэгжилтэд, Говь-Алтай аймгийн Иргэний Боловсрол төв аймгийнхаа олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагаанд, Үндэсний Соёмбо Хөдөлгөөн Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн газар олгох үйл ажиллагаанд, Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэд Залуучуудыг дэмжих “Гэгээ Мандал” Сан “Нийгмийн халамжийн тухай” хуулийн хэрэгжилтэд, Transparency International байгууллага Авилгын эсрэг хуулийн зарим заалтын хэрэгжилтэд тус тус мониторинг хийхээр болсон байна.

Эдгээр байгууллагын мониторинг хийх чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах, гарын авлага хэвлэн тараах, нэг бүрчлэн зөвлөгөө өгөх гэх мэт үйл ажиллагааг зохион байгуулж байна.



## ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА

Нээлттэй Нийгэм Форум 2006 онд уул уурхайн салбарын ил тод байдал, хариуцлага тооцох механизмыг бэхжүүлэх, иргэний нийгмийг чадавхижуулах чиглэлд урьдын адил анхаарлаа хандуулсны зэрэгцээ олон улсад эрчимтэй дэлгэрч буй Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОУИТБС)-ыг Монголд хэрэгжүүлэхэд түлхүү анхаарч ажиллалаа.

ННФ-ын нөлөөллийн идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд 2006 оны нэгдүгээр сард Монгол Улс Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгад нэгдэн орох болсныг Засгийн газар албан ёсоор мэдэгдсэн

төдийгүй уг санаачилгыг Монголд хэрэгжүүлэх зорилготой Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийг Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан байна. Засгийн газар, компани, иргэний нийгэм гэсэн гурван талын оролцоотой хэрэгжих ёстой уг санаачилгад иргэний нийгмийн идэвхтэй оролцоог бүрдүүлж чадавхижуулахад ННФ онцгойлон анхаарлаа. Тухайлбал, энэ санаачилгыг хэрэгжүүлэх сонирхол бүхий бусад 15 ТББ-тай нэгдэн Олборлох салбарын ил тод байдлын төлөө ТББ-уудын “Төлсөн авснаа нийтэл” эвслийг 2006 оны наймдугаар сард байгуулахад идэвхтэй оролцож, уг эвсэл үйл ажиллагаагаа явуулах санхүүжилтийг олголоо. Мөн ОУИТБС-ын Үндэсний зөвлөлд иргэний

нийгмийн төлөөлөл ороогүй байсан нь санаачилгын нийтлэг зарчмыг зөрчиж байсныг өөрчилж, уг эвслээс гурван төлөөлөгч, түүний дотор ННФ-ын гүйцэтгэх захирал энэ зөвлөлд орсон юм. Эвслээс таван төлөөлөгч (үүнд ННФ-ын менежер орсон) санаачилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ажлын хэсэгт орж, тодорхой асуудлаар өөрсдийн байр суурийг илэрхийлж байна. Түүнчлэн ННФ уг санаачилгыг түргэн шуурхай, иж бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байгааг олон нийт, бодлого боловсруулагчдад сануулж байсан төдийгүй эвслийн гишүүн байгууллагууд болон иргэний нийгмийн бусад байгууллага, сэтгүүлчдэд ОУИТБС-ын талаар байнга мэдээлж, хэрэгжүүлэх арга замын талаар санал солилцож ирлээ.

Иргэний нийгмийн байгууллагуудын уг санаачилгад оролцох чадавхийг бэхжүүлэх зорилгоор Дэлхийн Банк, Орлогын Ажиглагч Хүрээлэнтэй хамтарч ажилласан ба тэдний санхүүжилтээр зургаан иргэний нийгмийн байгууллагыг сонгон авч санаачилгыг сурталчлах, идэвхжүүлэх төрөл бүрийн төслийг хэрэгжүүлэхэд нь тэтгэлэг олголоо. Тухайлбал, олборлох салбарын орлогын байдалд дүн шинжилгээ хийх, ОУИТБС-

ыг олон нийтэд идэвхтэй сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг мэдээллээр хангах, орон нутгийн болон үндэсний төвшинд, төр засаг, компани, иргэний нийгмийн хооронд идэвхтэй яриа хэлэлцээр зохион байгуулах зэрэг чиглэлээр эдгээр байгууллага ажиллаж байгаа бөгөөд 2007 оны эхний улиралд үйл ажиллагаагаа дуусгавар болгоно.

“Төрийн ил тод байдал” үндэсний форумын хүрээнд ОУИТБС-ын талаар олон талын оролцоот яриа хэлэлцүүлэг өрнүүлж, Үйлдвэр Худалдааны Яам, ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, ажлын хэсэг, Уул Уурхайн Үндэсний Ассоциаци болон компаниуд, ТББ-уудын эвсэл болон бусад оролцогчид санаачилгыг хэрхэн хэрэгжүүлэх талаар санал зөвлөмж боловсруулан олон нийт болон бодлого боловсруулагчдад хүргэлээ.

Энэ бүх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс АНУ-д төвтэй Орлогын Ажиглагч Хүрээлэн, мөн “Төлснөө нийтэл” ТББ-уудын олон улсын эвсэл, түүний гишүүд, Дэлхийн Банктай идэвхтэй хамтран ажиллаж ирлээ. Цаашид ч уг санаачлагыг амжилттай хэрэгжүүлэхэд ННФ-ын гүйцэтгэх үүрэг өндөр байх ёстой гэж үзэж байна.



## ИРГЭДИЙН ОРОЛЦОО БА МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Шийдвэр гаргах үйл явцад иргэдийг оролцуулах нь аливаа асуудлыг шийдэх сонголтын хувилбар боломжийг нэмэгдүүлэх нэг үр дүнтэй нөхцөл болдог. Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, үр нөлөөг нь сайжруулахад чиглэгдсэн гол арга хэмжээ нь эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, түүнийг хэрэгжүүлэх тодорхой арга замыг бий болгох явдал юм. Ингэснээр аливаа хуулийг боловсруулах явцад иргэдийг оролцуулах тодорхой жишиг тогтоож, олон нийтийн хэлэлцүүлэг явуулах албан ёсны механизм бий болох юм.

Иргэдийн оролцооны талаар ерөнхийд нь ихээхэн ярьж бичиж, тунхаглаж байгаа боловч яг тухайлсан судалгаа төдийлөн хийгдээгүй байна. Иймд Нээлттэй Нийгэм Форум иргэдийн оролцооны эрх зүйн орчин болон институцчилал бий болгох талаас нь чухалчлан авч үзэх үүднээс 2005 оноос эхлэн бодлогын тэтгэлэгт хөтөлбөртөө уг сэдвийг оруулсан юм.

2005 онд хууль боловсруулах үйл явцад иргэдийн оролцооны асуудлыг авч үзсэн бол 2006 онд “Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад ТББ-ын оролцоо: эрх зүйн орчин

болон институцчиллыг сайжруулах нь” бодлогын судалгааг МУБИС-ийн багш Д.Бямбажав хийж гүйцэтгэлээ. Судалгааны зорилго нь Монгол Улсад төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад ТББ-ын оролцоог хангасан эрх зүйн орчин болон институцчиллыг сайжруулах арга замуудыг тодорхойлж бодлогын зөвлөмжийг боловсруулах явдал байлаа. Энэ хүрээнд:

1. Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад төрийн бус байгууллагын оролцоог зохицуулж буй өнөөгийн эрх зүйн болон институциональ орчинг тодорхойлох, давуу болон сул талуудыг илрүүлэх
2. Дэлхийн бусад орон дахь төр – иргэний нийгмийн хамтын ажиллагаа, ТББ-ын оролцоог хангасан сайн туршлагыг өөрийн орны нөхцөл, шаардлагад тулгуурлан хэрэгжүүлэх боломж, арга замуудыг тогтоох
3. Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад ТББ-ын оролцоог дэмжих бодлогын сонголтыг тодорхойлох зэрэг асуудлыг авч үзсэн байна. Судалгааны тайланг бодлого боловсруулагчид болон иргэний нийгмийн байгууллагуудад мэдээллийн эх сурвалж болох үүднээс хүргэлээ.

ННФ хууль боловсруулах, батлах үйл явцын ил тод байдлыг хангах, иргэдийн

болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор гадаадын дэвшилтэт туршлагаас суралцах, санаа авах боломжийг бүрдүүлэх, өөрийн нөхцөл байдалд тохирсон загварыг олж сонгоход дэмжлэг үзүүлэх санаачилгыг хэрэгжүүллээ. Энэхүү санаачилгыг Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Дорно Дорно - Хил Хязгааргүй Түншлэл бүсийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлсэн бөгөөд иргэдийн оролцоог амжилттай хангасан гэгддэг Словак улсад бодлого боловсруулагчдыг танилцах аялалд явуулав. Энэ үеэр Словак улсын Парламентын хууль боловсруулах, тогтоох үйл явц дахь иргэдийн оролцооны механизм, Хууль зүйн болон бусад яамны иргэдтэй зөвлөлдөх сайн туршлагууд, Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн оролцооны зохицуулалт, ТББ-ын нөлөөллийн боломж болон орон нутгийн төвшний оролцооны асуудлын талаар судалжээ.

Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Өргөдөл, гомдлоо хэрхэн гаргах вэ” гарын авлагыг Бүсийн Хөгжлийн Санаачилга ТББ-тай хамтран гаргалаа. Гарын авлагад иргэдийн өмнө тулгарч буй асуудлаар төрийн байгууллагуудад хандан өргөдөл, гомдол гаргах, түүнийг хүлээн авах, шийдвэрлэх үйл явцын талаар иж бүрэн мэдээллийг хялбаршуулсан хэлбэрээр хүргэсэн байна.

**“Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц дахь ТББ-ын оролцоо: эрх зүйн орчин болон институцчиллыг сайжруулах нь” бодлогын судалгааны дүгнэлтээс:**

- ТББ-уудын хувьд хууль, УИХ-ын бусад шийдвэрийг боловсруулах үйл явцад албан ёсоор оролцох хоёр л боломж байна. Нэгд, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үндсэндээ экспертийн хувиар оролцох /энэ нь цөөн хэдэн байгууллагаар хязгаарлагдана/, хоёрт, хэрэв байнгын хорооноос нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаад түүнд оролцохыг урьвал байр сууриа илэрхийлэх /эрх ашиг нь шууд хөндөгдөж байгаа эсхүл энэ асуудлаар ажиллаж буй бүлгүүд/ явдал. Аль ч тохиолдолд оролцогч талуудын хүрээ, боломж маш хязгаарлагдмал. Шийдвэр гаргах үйл явцад сонирхогч талуудын байр суурь, санаа бодлыг харгалзан үзэх явдал шийдвэр гаргагчдын сонирхлоос бүрэн хамаарсан шинжтэй байна.
- Хуулийн төслийг урьдчилан хэлэлцүүлэх үйл явц ихэнхдээ доноруудын санаачилга дэмжлэгтэйгээр, эсхүл Авилгын эсрэг хууль зэрэг олон нийтийн анхаарлын төвд орсон, байр суурийн хурц зөрчил бүхий хуулийн тухайд хийгдэж иржээ. Хэлэлцүүлгийн үр дүн, санал, дүгнэлтүүдийг төсөлд хэрхэн авч үзсэн нь тодорхойгүй, цаашид хэрхэн өөрчлөгдөж буй тухай мэдээллийг авах боломжгүй байна.
- ТББ-уудын оролцооны хамгийн түгээмэл хэлбэр нь улстөрчид, төрийн албан тушаалтнуудтай биечлэн уулзах явдал юм. Энэ нь хувь хүмүүсийн ажил хэргийн болон хувийн холбоонд тулгуурладаг тул сонирхогч аль нэг талд илүү давуу боломж олгож, бусдын зүгээс эргэлзээ, хардалтыг төрүүлдэг.
- Төрийн зүгээс ТББ-тай зөвлөлдөх, хамтран ажиллах бүтэц, механизм нь эхлэлийн шинжтэй, төрийн институцийн дотоод бүрдэл болон төлөвшөөгүй, улстөрийн өөрчлөлт, төрийн албан дахь сэлгээнээс шууд хамааралтай байна.
- Мэдээлэл солилцох, зөвлөлдөх, бодлогын яриа хэлэлцээр, хамтын үйл ажиллагааг дэмжин ажиллах чиг үүрэг бүхий төрийн нэгж байгууллага үгүйлэгдэж байна.



- Орон нутгийн төвшинд ТББ-ын ажилтнууд төрийн байгууллагад давхар алба хаших нь нийтлэг байгаа нь мэдээлэл, дэмжлэг олж авах боломжийг олгодог ч хараат бус бие даасан байдлыг нь хязгаарлаж байна.
- Бодлогын үйл явцад оролцож ирсэн байдлыг үзэхэд ТББ-уудыг бодлогын хүрээний болон хүрээний бус буюу түүний гаднах гэж ялгаж болохуйц байна. Бодлогын үйл явцад тогтвортой оролцож ирсэн, шийдвэр гаргагчидтай харилцаа холбоо тогтоож хамтран ажилладаг ТББ-ууд бодлогын хүрээнд байх бөгөөд харин шинээр байгуулагдсан, эсхүл төрд хяналт тавих чиг үүрэгтэй адвокати байгууллагын хувьд бодлогын хүрээнд ороход ихээхэн бэрхшээл тулгардаг.

Түүнчлэн иргэд өргөдөл, гомдлоо ихэвчлэн гаргадаг төрийн болон хуулийн байгууллагуудыг сонгон авч тэдгээрийн бүтэц, чиг үүрэг, хамаарах өргөдөл, гомдлын чиглэл, түүнийг шийдвэрлэх үйл явцын онцлогийн талаар дурдаж, ашиглах загвар, жишээ, холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм журам зэргийг хавсаргав.

2006 онд ННФ “Мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийн төслийг боловсруулан батлуулахад чиглэсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэн явууллаа. 2005 онд “Мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт Нээлттэй Нийгэм Форумын төлөөлөл багтсан бөгөөд хуулийн төслийг олон улсын жишигт нийцүүлэх үүднээс олон улсын

байгууллагуудаас санал зөвлөмж авч, төсөл боловсруулагчдад хүргэв. Хуулийн төслийг ХЗДХЯ-наас Засгийн газарт өргөн барьсан боловч Засгийн газрын 2006 оны 10 дугаар сард хэлэлцээд мэдээллийн аюулгүй байдлын асуудалтай багцлан оруулахаар буцаажээ. Иймээс УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил, Сү.Батболд, С.Оюун нар уг хуулийн төслийг санаачилан УИХ-д өргөн мэдүүлэх болсон. Хуулийн төслийн олон хувилбарыг ННФ-ын веб сайтад байрлуулан олон нийтэд толилууллаа. “Мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийн төслийг ойрын хугацаанд УИХ-аар батлуулах, хууль батлагдсаны дараа хэрэгжилтэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр ННФ үргэлжлүүлэн ажиллах болно.

## НУТГИЙН БОЛОН ТӨВЛӨРСӨН УДИРДЛАГА

Төв, орон нутгийн эрх мэдлийн хуваарилалт, зохист харьцааны тухай асуудал сүүлийн үед судлаачид, бодлого боловсруулагчид, иргэдийн анхаарлыг ихээр татах боллоо. Энэ нь 2003 онд батлагдсан Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн төвлөрөл дахин явагдаж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг өөрчлөх тухай яриа хэлэлцүүлэг идэвхжсэнтэй холбоотой юм.

Нээлтэй Нийгэм Форум төв, орон нутгийн эрх мэдэл, чиг үүргийн хуваарийн асуудлыг 2004 оноос эхлэн анхаарч, энэ чиглэлийг сонирхдог судлаачид, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ирлээ. 2005 онд “Монголын нутгийн удирдлагын асуудалд холбогдох номзүй” нэртэй бүтээлийг хэвлэн гаргаж, 1990 оноос өнөөдрийг хүртэлх хугацаан дахь нутгийн удирдлагатай холбоотой хууль, Засгийн газрын хөтөлбөр, бодлогын баримт бичиг, олон улсын байгууллагатай хамтарсан төсөл, мөн энэ сэдвээр гарсан ном, товхимол, гарын авлага, эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны тайлан зэргийг тоймлон товч тайлбартайгаар багтаалаа. 2005 онд ННФ орон

нутгийн эдийн засгийн чадавхи, засаглалын асуудлыг сонирхон ажиллаж, “Орон нутаг эдийн засгаа бие даан хөгжүүлэх боломж, арга зам”, “Төсөв санхүүгийн төвлөрөл ба орон нутгийн бие даасан байдал” сэдэвт хоёр судалгааг бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд эхлүүлсэн юм.

Сүмд эдийн засаг, нийгмийн асуудлаа бие даан шийдвэрлэх арга зам, нөөц боломж, хувилбарыг авч үзсэн эхний судалгаа 2006 онд бүрэн дуусч, эцсийн тайлан нь хэвлэгдлээ. Судалгаанаас үзэхэд орон нутгийн төвшинд Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын эрх мэдэл тэгш бус хуваарилагдсаны улмаас нутгийн иргэдээ төлөөлж байгаа ИТХ нь төрийн удирдлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй Засаг даргаас хараат болжээ. Эдийн засгийн асуудлаар шийдвэр гаргах эрх мэдэл нь ИТХ-д байгаа мэт боловч хөрөнгийн эх үүсвэр, бусад зохицуулалт байхгүйн дээр ИТХ-ын шийдвэрт Засаг дарга хориг тавих эрхтэй болсон зэрэг хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай асуудлууд цөөнгүй байна. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар салбарын төсвийн байгууллагууд босоо удирдлагатай

болсноор нутаг дэвсгэрийн харьяаллаар нэгдсэн бодлого, шийдвэр гарган хэрэгжүүлүүлэх орон нутгийн эрх мэдэл багасч, төвийн нөлөө их болжээ. Судалгаагаар сумын эдийн засгийн чадавхийг үнэлж үзэхэд дундаж болон томоохон хэмжээний сумд цаашид банк санхүү, татвар, төсвийн зохицуулалт хийгдсэн тохиолдолд бие даах боломжтой бол жижиг сумдын хувьд энэ нь тийм ч амар шийдэгдэхгүй нь харагдаж байна.

Төсөв, санхүүгийн төвлөрлийн асуудлыг орон нутгийн эрх мэдлийн хуваарилалтын асуудалтай холбон судалж байгаа хоёр дахь судалгаа нь шийдвэр гаргах эрх мэдлийг орон

нутагт олгохын зэрэгцээ хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг зохицуулалттай болгох шаардлагатай байна гэсэн урьдчилсан дүгнэлтийг хийгээд байна. Энэ хүрээнд төв, орон нутгийн хоорондын татварын харилцаа, төсөв батлах, зарцуулах асуудлаарх ИТХ-ын оролцоо зэрэг асуудлыг нарийвчилан судлахаар мэдээлэл цуглуулах ажил хийгдэж байна.

ННФ судалгааны ажлын зэрэгцээ “Иргэдийн Нийтийн хурал ба Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаа хэрхэн оролцох вэ” сэдэвт хялбаршуулсан тайлбарт гарын авлагыг боловсруулж эхлээд байна.

## НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ

1996 оноос Монголд тэтгэврийн шинэчлэлийн бодлого хэрэгжиж эхэлсэн боловч өнөөг хүртэл нийгэмд тодорхой мэдээлэл, нэгдсэн ойлголт бүрдээгүй байгаа нь энэ асуудлыг судлах хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна. Иймээс 2006 оны Бодлогын судалгааны хөтөлбөрийн хүрээнд ННФ нь тэтгэврийн “эв хамтын” тогтолцооноос “нэрийн дансны” тогтоцоо руу шилжих шилжилт хэрхэн явагдаж байгааг судалж, цаашид

хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын алхмуудыг зөвлөмж хэлбэрээр гаргахыг зорьж байна. Энэ судалгаа нь 1960 оноос өмнө төрсөн хүмүүст тэтгэвэр төлөхөд ашиглах хөрөнгийн эх үүсвэр, 1960 оноос хойш төрсөн хүмүүсийн тэтгэврийн дансны хадгалалт (шимтгэлээр төлсөн мөнгө дансанд бодитойгоор хуримтлагдаж байх), хамгаалалт (төсвийн дутагдлыг нөхөх гэх мэт зориулалтаар ашиглахгүй байх), эргэлтэд оруулах боломж зэрэг

асуудлыг хэрхэн зохицуулж байгааг судлах юм.

2006 онд хөдөө орон нутгийг мэдээлэл холбооны үйлчилгээнд хамруулах хэрэгцээ, боломж, хөрөнгийн эх үүсвэрийг судалсан бодлогын судалгааны тайлан эцэслэн хэвлэгдлээ. Зах зээлийн өрсөлдөөнт орчинд хүн амын нягтрал ихтэй газруудад холбоо харилцааны орчин үеийн сүлжээ, үйлчилгээнүүдийг бизнесийн байгууллагууд өөрсдөө оруулж байхад хэрэглэгч багатай алслагдсан сум, баг, сууринд энэ үйлчилгээ огт хүрэхгүй байгаа юм. Судалгаагаар хөдөө орон нутагт амьдарч байгаа хүмүүст энэ төрлийн үйлчилгээ нэн хэрэгтэй байгааг мэдээ мэдээлэл авах, мэдлэгээ нэмэгдүүлэх хэрэгцээгээр нь хэмжин авч үзжээ. Иймээс мэдээлэл холбооны үйлчилгээг хүн бүрт хүргэх зорилгоор бизнесийн байгууллагад ашиггүй эдгээр байрлалд мэдээлэл харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээг оруулахад

шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдэж болох нэг хувилбар нь бусад оронд туршигдсан “Бүх нийтийн үүргийн сан” байж болохыг манай бодлогын судлаач санал болгосон байна. Энэ нь тухайн үйлчилгээг эрхэлж байгаа бизнесийн байгууллагуудаас ашгийн хоёр хувьтай тэнцүү хэмжээний хөрөнгийг татаж, Засгийн газрын мэдлийн “Бүх нийтийн үүргийн сан”-д төвлөрүүлээд, тэр сангаасаа тендерийн хэлбэрээр төсөл шалгаруулах замаар алслагдсан газруудад интернет, хөдөлгөөнт суурин холбооны үйлчилгээг оруулах загвар юм. Сангаас санхүүжүүлэх төслийг тендерээр сонгох тул сангийн хөрөнгийг бүрдүүлэхэд оролцсон бизнесийн байгууллагууд энэ сангаасаа эргээд санхүүжилт авах эрх нь нээлттэй байх юм. Энэ саналыг манай орны нөхцөлд зохицсон оновчтой шийдэл гэж үзсэн тул Засгийн газрын тогтоолоор 2007 оноос хэрэгжүүлэх шийдвэр гараад байна.

## ЭРХЗҮЙН ТУСЛАЛЦАА

Монголын хүн амын дунд ядуу иргэдийн эзлэх хувь өндөр, улмаар тэдгээр хүмүүс гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд өмгөөлөгч авах боломж хомс байгаа тул төлбөрийн чадваргүй иргэдэд эрх

зүйн туслалцаа үзүүлэх нь хүний эрхийг хангахад чухал үүрэгтэй юм. Хуулийн хэрэгжилт, туслалцаа үзүүлэх ажлын уялдаа сул, санхүүжилт хомс зэрэг олон шалтгаанаас үүдэн төлбөрийн

чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх нь тулгамдсан асуудал болж байна.

Төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулахад Нээлттэй Нийгэм Форум дэмжлэг үзүүлэн ХЗДХЯ-тай хамтран ажиллаж байна. Будапештэд төвтэй “Нээлттэй Нийгмийн Эрхзүйн Санаачилга” байгууллагатай хамтран “Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрхзүйн туслалцаа” төслийг 2006 онд үргэлжлүүлэн хэрэгжүүллээ. ХЗДХЯ-наас төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг хариуцсан үндэсний тогтолцоог бий болгох; тэдэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэг бүхий Зөвлөл байгуулах; өмгөөллийн туслалцааны төвүүдийг үндэсний хэмжээнд байгуулах; эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, төрийн бус байгууллагууд, хууль зүйн клиникүүдийн үйл ажиллагааг дэмжин уялдааг хангах; орон нутагт эрх зүйн мэдээлэл, лавлагаа, хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагааг багтаасан “Төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, санал зөвлөмж авах ажлыг зохион байгуулав. Энэхүү үндэсний хөтөлбөрийг 2006 оны 12 дугаар сард Засгийн Газар баталсан бөгөөд 2007 оноос эхлэн

хэрэгжүүлэхээр боллоо.

Сонгинохайрхан дүүрэг болон Хэнтий аймаг дахь төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх туршилтын төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулж байна.

ННФ ХЗДХЯ-тай хамтран орон нутагт эрх зүйн боловсрол, мэдээлэл, зөвлөгөө лавлагааны тогтолцоог боловсронгуй болгох үүднээс “Эрх зүйн мэдээлэл, үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэх нь” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлээ. Төслийн эхний үр дүн болгон анхан шатны эрх зүйн зөвлөгөө ба эрх зүйн боловсролыг төрийн үйлчилгээ болгон хэвшүүлж орон нутгийн удирдлагад институцчилан бэхжүүлэх стандартыг бий болгох үүднээс орон нутгийн ЗДТГ-ын хуулийн хэлтсийн ажилтнуудын ажил үүргийн шинэ хуваарийг ХЗДХ-ийн сайд батлан бүх аймгийн Засаг дарга нарт албан ёсоор хүргүүлсэн байна. Түүнчлэн иргэдэд эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулахаар болсны дагуу ХЗДХЯ-нд тайлагнах албан ёсны стандартыг батласнаар энэхүү чиг үүргийг хэвшүүлэн тогтооход чухал үүрэг гүйцэтгэлээ.

Хуулийн ажилтнуудын үйл ажиллагаандаа ашиглах болон иргэдэд зориулсан анхан шатны, хялбаршуулсан гарын авлагуудыг боловсрууллаа. Гарын авлагыг зохиогчдод зориулан зөвлөхүүдтэй хамтран хоёр удаа сургалт зохион байгуулав.



## СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ

Нээлтэй Нийгэм Форум стратегийн өмгөөллийн тухай ойлголтыг Монголд нэвтрүүлэх, улмаар Монголын хуульч, өмгөөлөгчид олон нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалдаг туршлагыг бий болгох зорилгоор 2006 онд тодорхой үйл ажиллагаа явуулаа. Стратегийн өмгөөлөл гэдэг нь тодорхой үйлчлүүлэгчийн эрх ашгийг төлөөлдөг уламжлалт өмгөөллөөс огт өөр ойлголт бөгөөд нийгэм, эрх зүйн өөрчлөлт шинэчлэлд чиглэсэн, олон нийтийн эрх ашгийг хөндсөн, цаашид жишиг болохоор асуудлыг хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенци ашиглан шүүхээр нэхэмжлэн хамгаалах өмгөөллийн үйл ажиллагаа юм.

Дэлхий дахинаа өргөн хэрэглэгддэг хэдий ч манай улсын хувьд шинэ эл ойлголтыг Монголд нэвтрүүлэхэд дэмжлэг болгох үүднээс “Стратегийн өмгөөлөл: нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь” гарын авлагыг Хүний Эрх Хөгжил Төвтэй хамтран боловсруулан хэвлэлээ. Гарын авлагад стратегийн өмгөөллийн тухай ойлголт, ач холбогдол, үүсэл, хөгжил, Монгол дахь стратегийн өмгөөллийн анхны оролдлого, туршлагын талаар өгүүлсэн бөгөөд ийм өмгөөллийг хэрхэн хийх талаар аргагүйн зөвлөмж өгсөн байна. Түүнчлэн хүний эрхийг хамгаалах НҮБ-ын механизмийг хэрхэн ашиглах талаар болон стратегийн өмгөөллийн

байгууллагуудын тухай мэдээллийг багтаасан болно.

Стратегийн өмгөөллийн асуудлаар ТББ-ууд болон өмгөөлөгчдөд зориулсан цуврал сургалт зохион байгуулахаар болж, эхний сургалтыг 2006 оны гуравдугаар сард явууллаа. Энэхүү сургалтаар байгаль орчныг хамгаалах чиглэлд түлхүү анхаарсан бөгөөд 30 гаруй ТББ-ын төлөөлөгчид, хуульчид, өмгөөлөгчид оролцов. Сургалтыг АНУ-д төвтэй Глобал Райтс байгууллагатай хамтран явуулж, АНУ-ын байгаль орчны чиглэлээр ажилладаг ТББ-уудын туршлагатай өмгөөлөгч хуульчид хөтлөн явууллаа.

Үндсэн хуулинд заасан хүний эрх, эрх чөлөөний зөрчлийн асуудлаар Үндсэн хуулийн Цэцэд хандах аргачлал, аргазүйн зөвлөгөөг ТББ-уудын ажилтнуудад өгөх зорилгоор ННФ 2006 оны 12 дугаар сард “Үндсэн хуулийн Цэцэд хэрхэн хандах вэ” сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд ҮХЦ-ийн дэд дарга Н.Жанцан “Цэцийн бүтэц, чиг үүрэг, цэцэд хандсан маргаан хэрхэн шийдвэрлэгдсэн байдал”, МУИС-ийн ХЗДС-ийн захирал, профессор С.Нарангэрэл “Цэцэд хандаж болох асуудлыг хэрхэн тодорхойлох” талаар

тус тус танилцуулсан байна. Цэцэд хандсан өргөдөл, мэдээллийг хэрхэн бичих талаар практик ажлыг Д.Ламжав удирдан явуулав. Хүний эрхийн асуудлаар Үндсэн хуулийн Цэцэд хандах талаар ТББ-ууд тодорхой туршлага олж авсан нь энэхүү сургалтын нэг гол ач холбогдол байлаа.

Стратегийн өмгөөллийн жишиг загварыг бий болгох зорилгоор Хүний Эрх Хөгжил төвд тэтгэлэг олгов. Ингэснээр уул уурхайн бүсэд оршин суугаа иргэдийн нийтлэг эрх ашгийг шүүхээр хамгаалахад холбогдох хуулийн заалтуудыг хэрэглэх практикийг бий болгохыг зорьж байна. Энэ чиглэлээр ажилладаг хуульч, өмгөөлөгчдийн чадавхийг сайжруулах, ялангуяа нийтийн эрх ашгаа шүүхээр хамгаалах талаар иргэдийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэхэд энэхүү төсөл тус болно гэж үзэж байна. Төслийн хүрээнд байгаль орчны асуудалд холбогдох 10 хэргийг сонгон шүүхэд нэхэмжлэл гаргаж, стратегийн өмгөөлөл явуулах хуульчдын багийг ажиллуулах, стратегийн өмгөөлөл хийх идэвхи санаачилгыг холбогдох байгууллага, хуульч, өмгөөлөгчдийн дунд өрнүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэлэлцүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм.

## ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Нээлтэй Нийгэм Форум 2003 оноос эхлэн анхаарч ирсэн билээ. Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгтэй хамтын ажиллагаагаа 2006 онд үргэлжлүүлж, олон улсын жишиг стандартад нийцүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх, хамгийн гол нь энэ үйл явцын ил тод байдлыг хангах, ялангуяа хуулийн төсөл боловсруулахад ТББ-уудын оролцоог хангах, санал бодлыг тусгахад түлхүү анхаарсан болно. Ажлын хэсгийн уулзалт зохион байгуулах, мэдээлэл, эх сурвалжаар хангах зэрэг үйл ажиллагаа хийгдлээ.

2006 онд ННФ ТББ-уудын дотоод зохицуулалтын асуудалд түлхүү анхаарч ажиллав. ТББ-ууд нь нийгмийг хөдөлгөгч нэг гол хүчний хувьд энэ салбарын ил тод, хариуцлагатай байдал нь нийгмийн хөгжил, дэвшилд чухал үүрэг нөлөөтэй юм. ТББ-уудын ил тод, хариуцлагатай байдал нь тэдгээрийн дотоод засаглалын асуудалтай салшгүй холбоотой бөгөөд энэ бол Монголын хувьд шинэ ойлголт юм.

ТББ-уудын дотоод засаглалыг бэхжүүлэх чиглэлээр гарын авлага бэлтгэх, сургалт зохион байгууллаа. Зүүн болон Төв Европын орнуудын ТББ-уудтай 2004 онд Мэрилин Уайтын хамтран боловсруулсан “ТББ-ын засаглалын удирдамж” гарын авлагыг Монгол

хэлнээ орчуулан бэлтгэв. Энэ гарын авлагад ТББ-ын засаглалын үндсэн зарчим, стандартууд, тэдгээрийг практикт нэвтрүүлэх удирдамжийн талаар өгүүлсэн байна. Тухайлбал, ТББ-ын удирдлагын бүтэц, Удирдах зөвлөлийн чиг үүрэг, хариуцлага, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг асуудлыг тусгажээ.

ТББ-ын дотоод засаглалын ойлголтыг улам бэхжүүлэх, практик үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ТББ-уудад зориулсан сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Сургалтыг дээр дурдсан гарын авлагын зохиогч хөтлөн явуулах юм. Түүнчлэн цаашид энэ чиглэлээр ТББ-уудад сургалт явуулах, зөвлөгөө өгөх сургагч багш нарыг бэлтгэх үйл ажиллагаа хийгдэнэ.

ННФ нь ТББ-уудын лавлахыг шинэчлэх ажлыг мөн эхлүүллээ. Энэхүү лавлахыг ННФ 2002 онд гаргаж байсан бөгөөд түүнээс хойш маш олон ТББ шинээр байгуулагдсан төдийгүй ихэнх нь үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, хаягийн хувьд өөрчлөгджээ. Энэхүү төслийг ХЗДХЯ-тай хамтран хэрэгжүүлж буй бөгөөд ХЗДХЯ-ны ТББ-ын бүртгэлийг шинэчилж мэдээллийг цахим баазад оруулан веб сайтад байрлуулан тогтмол баяжуулах юм. ТББ-ын лавлах номонд ТББ-уудыг зорилго, үйл ажиллагааны чиглэлээр нь ангилна.





Эдийн Засгийн Хөгжлийн Бодлого



НЭЭЛТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

**2006**  
ЖИЛИЙН ТАЙЛАН

## ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКС

Нээлтэй Нийгэм Форум 2005 оноос эхлэн эдийн засгийн эрх чөлөөний асуудалд анхаарлаа хандуулан тодорхой ажлуудыг хийж байна. ННФ дэлхий дахинаа эдийн засгийн эрх чөлөөг хэмждэг томоохон судалгааны институт болох Фрейзер институттэй (ФИ) түншлэн ажиллалаа. 2006 онд Монгол Улс анх удаагаа тус интитутаас гаргадаг Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индекст (ДЭЗЭЧИ) хамрагдсан юм. Түншлэгч байгууллагын хувьд Форумын зүгээс тоон мэдээллийг өгөх, тус улсын талаар тооцоолсон индексийг шалгах зэргээр ажилласан болно. Монгол дахь эдийн засгийн эрх чөлөөг хэмжих чадавхийг бэхжүүлэх явдлыг дэмжих, эдийн засгийн эрх чөлөөний гол асуудлуудад бодлого боловсруулагчид, олон нийтийн анхаарлыг хандуулах нь энэ ажлын гол зорилго юм. Энэ үүднээс ННФ “Монголын эдийн засгийн эрх чөлөөний жилийн тойм – 2006” (МЭЗЭЧЖТ)-г Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуультай хамтран боловсруулж гаргалаа. Энэхүү тойм нь жил бүр хэвлэгдэх бөгөөд тухайн жилийн эдийн засгийн шийдвэрлэх асуудлуудаас хамаарч жил бүр өөр өөр сэдвийг хөндөх юм. Сэдвийг сонгохдоо ФИ-ийн ДЭЗЭЧИ, Дэлхийн Эдийн Засгийн Форумын Дэлхий дахины

өрсөлдөх чадварын тайлан (ДДӨЧТ), Транспаренси Интернэшнл-ийн Авилгын индекс, Дэлхийн Банкны Засаглалын индекс болон Бизнес эрхлэх нь зэрэг эдийн засаг, засаглалын индексүүдийн шинжилгээг ашиглах болно.

2006 оны Монголын эдийн засгийн эрх чөлөөний тоймын гол чиглэл нь эдийн засгийн өсөлт, хүний хөгжилд ихээхэн ач холбогдолтой эдийн засгийн эрх чөлөөний байдлыг Монгол Улсын өнөөгийн төвшинд дүгнэж, институцийг сайжруулснаар эдийн засгийн өсөлтийг түргэтгэх боломжийг загварын хүрээнд тогтоож, шинээр трансакцийн зардлыг тооцоолох явдал байлаа. Түүнчлэн институцийн хөгжлийн хүрээнд Монгол Улс дахь өмчийн эрх болон гэрээний биелэлтийн асуудлыг судалж эдгээр нь хувийн секторын хөгжилд ямар нөлөө үзүүлж буйг тодорхойлсон. Энэхүү жилийн тоймын үр дүн, санал зөвлөмжийг бодлого боловсруулагчид, эдийн засагчид, санхүүгийн томоохон бүлэг, компаниудын тэргүүнүүд, Засгийн газрын холбогдох албан тушаалтнууд, судлаачдад танилцуулан хэлэлцүүлж тэдний санаа бодол, санал шүүмжийг тоймын эцсийн хувилбарт тусгалаа. Энэ төрлийн уулзалт ярилцлага нь эдийн засгийн эрх чөлөөнд тулгарч буй хүндрэл бэрхшээл, гол асуудлуудад

олон нийтийн анхаарлыг хандуулахад тус дөхөм болж байгаа юм. Уулзалт хэлэлцүүлгүүд нь Монголын эдийн засгийн бодлогын талаар илүү өргөн хүрээтэй мэтгэлцээн өрнөхөд хүргэнэ гэж ННФ үзэж байна.

ННФ татвар цуглуулах механизм,

Засгийн газрын төсвийн зарцуулалтын үр өгөөжийг сайжруулах чиглэлээр бодлогын судлаачдыг сонгон ажиллуулж байна. Судлаачид эдгээр асуудалтай холбоотой өнөөгийн эрх зүйн болон практик нөхцөл байдлыг судалж, цаашид сайжруулах бодлогын хувилбаруудыг санал болгох юм.

## МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

Шилжилтийн эдийн засаг бүхий, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн багатай орнуудын дотроос Монгол Улс нь нээлттэй зах зээлийн эдийн засгийн үндэс суурийг тавих талаараа багагүй ахиц дэвшил гаргаад байгаа ажээ. Ардчилсан шилжилтийн үе дуусах шатандаа орж, хамгийн хүнд хэцүү ажил үлдсэн энэ үед манай улс дэлхийн эдийн засаг дахь өрсөлдөх үүргээ хөгжүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна. Ингэснээр аль болох нээлттэй, ардчилсан нийгэм бий болгох эдийн засгийн үндэс суурийг бэхжүүлэх бөгөөд тогтвортой, өргөн хүрээтэй, тэгш шударга, хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийн үндсүүдийг тавих юм.

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагаас санхүүжүүлсэн Эдийн Засгийн Бодлогын Шинэчлэл, Өрсөлдөх Чадвар төслийн хүрээнд (ЭЗБШӨЧТ

буюу EPRC) Дэлхийн Эдийн Засгийн Форумын /ДЭЗФ/ 2005 оны өрсөлдөх чадварын судалгаанд Монголыг хамруулах ажлыг эхэлсэн бөгөөд түүнээс хойших жилүүдэд энэ судалгааг хийх ДЭЗФ-ын үндэсний түншлэгч байгууллагын үүргийг Форум гүйцэтгэх болсон. Энэ үүргийн нэг хэсэг болгож Форумтаас дэлхий дахины өрсөлдөх чадварын асуудлаар бизнесийнхэнтэй цуврал уулзалт ярилцлага хийж байна. ННФ Хүман Фортис Консалтанси компанитай хамтран 104 үйлдвэр, аж ахуйн газрыг хамарсан “Бизнесийн удирдлагуудын санаа бодол”-ын судалгааг хийлээ. Эдгээр газар нь эдийн засаг, бизнесийн гол салбарууд, жижиг, дунд, том компаниудын төлөөллийг хамарсан юм.

Анхны зэрэглэлд хамрагдсан байдлаас үзэхэд Монгол Улс Дэлхийн Эдийн

Засгийн Форумаас гаргадаг Өсөлтийн өрсөлдөх чадварын индекс (ӨӨЧИ)-т орсон 117 улсаас 96 дугаар байрт бичигдсэн байна. ДЭЗФ-ын “Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан 2005-2006” -гийн улс орон бүрт холбогдох мэдээлэлд танилцуулснаар Монголын тэргүүлэх бизнесийн удирдлагууд “бизнес эрхлэхэд хамгийн бэрхшээлтэй хүчин зүйлсэд дараахь шалтгаануудыг тооцжээ. Үүнд төр, засгийн үр ашиггүй хүнд суртал, дэд бүтэц сул, авилга, татварын зохицуулалт, санхүүжилт олж авах боломж, ажиллах хүчний боловсрол, үндэсний ажиллах хүчний ажлын ёс суртахуун муу зэрэг орсон байна.

Хэрэгжиж болохуйц тодорхой санал боловсруулан байнгын хяналт тавьж ажиллах тал дээр хувийн хэвшил, Засгийн газар хоёр хамтран ажиллах нь улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд нэн тустай байдаг. Хувийн хэвшил болон Засгийн газрын түншлэлд гарах ололт амжилтыг үнэлж дүгнэхэд Монгол Улсын өсөлтийн өрсөлдөх чадварын индекс эзэлсэн анхны зэрэглэлийг ашиглаж болно. Энэхүү индекс Монголын цаашид эзлэх байр суурь нь ололт амжилтыг хэмжих гадаад хэмжүүр буюу эдгээр хүчин чармайлтын үр дүнг үнэлэх “онооны талбар” болж өгөх юм.

ННФ Монголд хэрэгжиж болохуйц улсын хийгээд хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрэлхийлсэн хөтөлбөр боловсруулахыг санал болголоо.

Энэ төрлийн хамтын ажиллагаа нь Монголын бизнесийн орчны өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн тодорхой хөтөлбөр боловсруулахад дэмжлэг үзүүлэх чухал үүрэгтэй гэж ННФ үзэж байна. ННФ, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ), Үйлдвэр, Худалдааны Яам (ҮХЯ), ЭЗБШӨЧТ зэрэг байгууллагууд улсын ба хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн боломжит механизмуудыг олж тогтоох үйл явцын анхны түншлэгчид болсон юм. 2005 оны 12 дугаар сард манай Форум, ЭЗБШӨЧТ ба ҮХЯ-тай хамтран хамтын үйл ажиллагааны механизмыг судлах зорилгоор хувийн хэвшлийн бизнесийн удирдлагууд, хандивлагчдын дунд анхны уулзалтыг зохион байгууллаа. Уулзалт хэлэлцүүлгийн үр дүнгээс үзэхэд агентлагуудын бодлого, зохицуулалтад нөлөөлөх үйл ажиллагааны механизм дутагдалтай байна гэдэгтэй оролцогчид санал нэгдсэн боловч үүнд хамгийн их хамааралтай ямар асуудал байна, тэдгээрийг хэрхэн авч үзэх вэ гэдэг дээр харин нэгдсэн зөвшилцөлд хүрч чадаагүй байна. Хувийн хэвшлийн зохион байгуулалттай, үр дүнтэй нөлөөллийн асуудал өнөөдөр Монгол Улсад дөнгөж бүрэлдэн тогтох шатандаа явж байна. Томоохон компаниуд хувийн хэлхээ холбоогоороо дамжуулан төр, засгийн байгууллагуудаар асуудлаа шийдвэрлүүлэх хандлагатай байгаа нь жижиг, дунд хэмжээний аж ахуйн газрын хувьд тэр бүр тохиодоггүй хяслан юм.

Эдийн засгийн өрсөлдөх чадварын

үзэл баримтлалыг дэмжин сурталчлах үүднээс ННФ, ЭЗБШӨЧТ-тэй хамтран “Дэлхий дахины өрсөлдөх чадварын тойм 2005-2006” номын хэсгийг орчуулж, бизнесийн байгууллагууд, номын сангууд, их дээд сургуулиуд, бизнесийн холбоод, парламентын гишүүдэд тараалаа.

Мөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шударга Бус Өрсөлдөөнийг

Хянан Зохицуулах Газрын (ШБӨХЗГ) гаргасан санаачилгын нэг хэсэг болгож ННФ-аас бизнесийн байгууллагууд, тус газрын ажилтнуудын хооронд дугуй ширээний ярилцлага зохион байгуулсан нь бизнесийн салбар дахь шударга өрсөлдөөний эрх зүйн болон практик орчныг сайжруулах талаар ШБӨХЗГ-тай цаашид хамтран ажиллах үндэс суурь болж өгсөн юм.



## ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Сумын төвшинд орон нутгийн эдийн засгийг иргэдийн өөрсдийнх нь оролцоо, дэмжлэгтэйгээр хөгжүүлэх зорилгоор Нээлттэй Нийгэм Форум 2006 онд Будапешт дахь LGI буюу Нутгийн Захиргааны Санаачилга байгууллагатай хамтран “Оролцогчдын хамтын

ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх/ДЕЛТА” төслийг санаачилсан юм. DELTA (“Develop Enterprise Locally through Alliance and Action”) төсөл нь сумын төвшинд бодлогын шинэчлэл хийж, хувийн хэвшлийг хөгжүүлэх стратеги, үйл ажиллагааны

төлөвлөгөөг боловсруулахад чиглэж байна. Энэ төсөл нь орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн тэргүүлэх бизнесмэнүүдийн чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаанд тулгуурлан хэрэгжих юм. Мөн төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийг институцижүүлэх, орон нутгийн хөгжлийн төслүүдийг боловсруулах явцад бизнесийн салбарыг илүү сайн хөгжүүлэхэд чиглэсэн стратеги, алсын хараа бий болгоход чиглэсэн хамтын ажиллагааг өрнүүлж байна.

ДЕЛТА төслийг хэрэгжүүлэхэд дотоодын түнш байгууллага болгон Бодлого Судлалын Төв (БСТ)-тэй хамтран ажиллаж төслийн хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Юуны өмнө туршилтын төсөл хэрэгжүүлэх сумыг Монгол Улсын нийт 331 сумаас сонголоо. Эхний сумдыг дэд бүтцийн хөгжил, хүн амын тоо болон хөдөө аж ахуй, аялал жуулчлал, байгалийн баялаг гэх мэт эдийн засгийн гол салбаруудын өсөлтийн шалгуурт үндэслэн сонгосон. ДЕЛТА-г хэрэгжүүлэх орон нутгийн сонирхол, сум бүрээс дэвшүүлсэн орон нутгийн багийн бүрэлдэхүүн ба чадавхи, ирүүлсэн өргөдлийн иж бүрэн байдал ба чанар, өргөдөлд орсон мэдээллүүдийн баттай байдал гэх мэт тусгай багц шалгуурууд ашиглан хоёрдугаар шатны сонголтыг

хийсэн болно. Эцсийн шатанд үлдсэн есөн сумын багтай ярилцлага хийсэн бөгөөд уг ярилцлагын үр дүнд ДЕЛТА төслийг хэрэгжүүлэхээр дөрвөн сум тодорсон нь Хөвсгөл аймгийн Тариалан, Архангай аймгийн Ихтамир, Увс аймгийн Тариалан, Баянхонгор аймгийн Баянхонгор сумд байлаа.

Төслийн хүрээнд орон нутгийн засаг захиргаа, хувийн сектор, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн багийн гишүүдэд орон нутгийн эдийн засгийн хөгжлийн стратеги боловсруулах чадавхийг бий болгох зорилгоор цуврал сургалт семинар явуулах төлөвлөгөөний дагуу 2006 оны найм, 12 дугаар сард хоёр удаа сургалт зохион байгуулав.

Одоогийн байдлаар сонгосон дөрвөн сумын хувьд орон нутгийн бизнесийн орчны судалгаа, SWOT шинжилгээ хийж судалгааны үр дүнг орон нутгийн нийт иргэдийн төлөөлөгчдөд танилцуулан хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг өрнүүлээд байна. Түүнчлэн орон нутаг дахь бизнесийн байгууллагуудыг зах зээлийн аливаа мэдээллээр хангах, бусад үйлчилгээг үзүүлэх замаар орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий Орон нутгийн бизнесийн хөгжлийн алба байгуулан ажиллуулах тухай төслийг сум бүр боловсруулан ажиллуулж эхлээд байна.



## УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БОДЛОГЫН АСУУДАЛ

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын эдийн засагт үзүүлэх үр нөлөө, бодлогын асуудлаар Монголын нийгэмд өргөн хүрээтэй мэтгэлцээн тасралтгүй өрнөж байна. Улс орны эдийн засгийн өсөлтийн гол тэргүүлэх салбар гэдэг утгаар нь Нээлттэй Нийгэм Форум уг мэтгэлцээнийг өрнүүлэхэд чухал үүрэгтэйгээр оролцож ирлээ. 2006 он Монгол Улсын уул уурхайн салбарын хувьд бодлого чиглэлээ дахин тодорхойлох хариуцлагатай жил болов. ННФ энэ онд тус салбарын тулгамдсан асуудлаар бодлогын судалгаа, дүн шинжилгээ хийх, тодорхой өөрчлөлтүүд хийхийг дэмжих замаар идэвхтэй, бүтээлч байр сууринаас хандлаа.

Юуны өмнө Ашигт малтмалын тухай

хууль, Татварын багц хууль, Гэнэтийн ашгийн татварын хууль зэрэг уул уурхайн салбарын эдийн засгийн ерөнхий орчныг тодорхойлогч гол хуулиуд шинэчлэгдсэн буюу шинээр батлагдсантай холбоотойгоор бодлогын цоо шинэ асуудлууд гарч ирэв. ННФ уул уурхайн салбарт татвар ногдуулах, төр, засагт орох орлогын ил тод байдал, томоохон орд газруудын хувьд гадаадын хөрөнгө оруулагч нартай хөрөнгө оруулалтын хэлэлцээр хийх зэрэг асуудлуудад гол анхаарлаа төвлөрүүллээ.

Ашигт малтмалын тухай хуулийн хувьд хуулийн төсөл дээр Орлогын Ажиглагч Хүрээлэнтэй хамтран Дюкийн Их Сургуулийн профессор Конрад, олон улсын хуульч Бэлл зэрэг зөвлөхүүдийн

тусламжтайгаар иж бүрэн шинжилгээ хийж, гол гол асуудлаар өөрсдийн байр суурь, санал зөвлөмжийг УИХ гишүүд, хууль боловсруулах ажлын хэсэг болон олон нийтэд тухай бүрт нь хүргэлээ. Мөн гэнэтийн ашгийн татварын тухайд ашигт суурилуулан тооцох, суурь үнийг олон улсын зах зээлийн үнээр тооцохын ач холбогдол зэрэг олон асуудлыг эдгээр зөвлөхүүд хөндөн хууль боловсруулах ажлын хэсэгтэй санал солилцлоо. УИХ-ын эдийн засгийн байнгын хорооноос Ашигт малтмалын тухай хуулийн төслийг хэлэлцэх хүрээнд зохион байгуулсан нээлттэй хэлэлцүүлгийн үед ННФ-ын баг нөөц ашигласны төлбөрийг нэмэгдүүлэх талаар судалгаа хийн үр дүнг нь танилцуулсан нь эцсийн дүндээ уг хуулинд тусгагдсан болно. Гэнэтийн ашгийн татварын тухай хуулийн төслийг хэлэлцэх үеэр өөрсдийн байр сууриа Уул уурхайн үндэсний чуулганд мөн танилцууллаа.

Энэ зөвлөхүүд маань Айвенхоу Майнз компанитай Оюу толгой орд газрын хувьд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах Монголын Засгийн газрын ажлын хэсгийнхэнд зориулж хоёр өдрийн сургалт зөвлөгөөн зохион байгуулав. Энэ үеэр Засгийн газар болон компани тодорхой урьдчилсан нөхцлийн хувьд хүртэх ашиг, үүрэх эрсдлийг тооцох санхүүгийн загварыг боловсруулснаа ажлын хэсгийнхэнд танилцуулж хүлээлгэн өгсөн. Мөн олон улсын хууль, байгаль орчны зохицуулалт, төрийн оролцоо зэрэг

олон чухал асуудлаар санал бодлоо нээлттэй солилцсон болно.

ННФ хэд хэдэн чиглэлээр бие даасан судалгааны ажил захиалан хийлгэж, чингэхдээ үндэсний мэргэжилтнүүдийн бодлогын судалгаа, шинжилгээний чадавхийг нэмэгдүүлэхийг зорив. Монгол Улс дахь Голланд өвчин, уул уурхайн салбар дахь ажил эрхлэлтийн асуудал зэрэг сэдвээр бодлогын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд судлаач авч ажиллууллаа. Монголд эрдсийн сан байгуулах шаардлага, арга замын талаар бие даасан судлаач судалгаа хийж, үр дүнг нь олон нийтээр хэлэлцүүлж, бодлого боловсруулагчдад хүргэсэн нь ихээхэн ач холбогдолтой ажил боллоо.

Түүнчлэн ашигт малтмал, татварын тухай хуулиудыг УИХ-аар хэлэлцэх үеэр уул уурхайн салбарын тусгай зөвшөөрөл, татварын асуудалтай холбоотой хэлэлцүүлгийг Форум ТВ хөтөлбөрийн хүрээнд хийсэн нь олон нийтэд асуудлыг ойлгуулах, бодлого боловсруулагчдад иргэний нийгмийн болон компанийн төлөөлөгчид үгээ хүргэх сайхан боломж олгов.

Уул уурхайн салбарын талаарх бодлогыг тодорхойлоход ННФ идэвхтэй оролцож ирсэн нь тодорхой үр дүнд хүрсэн гэж үзэж, цаашид хөрөнгө оруулалтын гэрээ, хариуцлагатай уул уурхай, салбараас олох орлогын хуваарилалтын асуудал зэрэг өргөн хүрээтэй сэдвээр үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна.



## ГАЗРЫН ШИНЭТГЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Нээлттэй Нийгэм Форум өмнөх жилүүдэд газрын шинэтгэлийн бодлогын асуудалд түлхүү төвлөрч ажилласан бол 2006 оноос бодлогын хэрэгжилтэд мониторинг хийх үйл ажиллагаанд гол анхаарлаа хандууллаа.

Газрын хувьчлал, газар олголттой холбоотой хуулиудын хэрэгжилтэд мониторинг хийх зорилгоор дотоодын гурван төрийн бус байгууллагад ННФ тэтгэлэг олголоо. Эхний хоёр мониторингоос газрын албадын ажилтнууд газрын шинэтгэлийн талаар хангалттай мэдлэг мэдээлэлгүй, газар олголтод холбогдох зөрчил маргааныг шийдвэрлэх тодорхой арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх бэлтгэлгүй байна гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Газрыг өмчлөх, эзэмших талаар иргэд зохих хэмжээний мэдлэг мэдээлэлгүй байгаа нь газрын шинэтгэлийн үйл явцад сөрөг нөлөө үзүүлж байгааг тогтоожээ. Эдгээр төслийн хүрээнд иргэд болон төрийн албан хаагчдад зориулсан цуврал гарын авлага гарч, холбогдох албан туршаалтнууд, олон нийтэд хүргэлээ.

Гуравдахь төслийг Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн холбооноос хэрэгжүүлсэн бөгөөд барилга барих зорилгоор газар олгох асуудалд

мониторинг хийв. Мониторингийн үр дүнгээс үзэхэд сургууль, цэцэрлэг, ногоон байгууламж зэрэг газарт иргэд болон аж ахуйн нэгжүүдэд хууль бусаар газар олгож байгаагаас газрын маргаан үүсэх нь түгээмэл болжээ. Судалгааны хүрээнд хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, газрын маргаантай холбоотой шүүхийн шийдвэрт дүгнэлт өгч, зорилтот бүлгүүдээс санал асуулга авсан байна. Мониторингийн үр дүнд хууль тогтоомжийг сайжруулах, газар олголтын ил тод байдал, хариуцлага тооцох тогтолцоог бэхжүүлэх талаар санал зөвлөмж боловсруулсан байна. Монголын Эд Хэрэглэгчдийн Хоршоодын төв холбооноос орон сууцны хорооллын хүүхдийн тоглоомын талбайд газар олгож байгаа явдалд мөн мониторинг хийж, энэ хүрээнд цуглуулсан зөрчлүүдийн талаарх мэдээлэлд үндэслэн төрийн тодорхой албан хаагчдад байдлыг засч залруулах талаар шаардлага хүргүүлсэн байна.

“Төрийн ил тод байдал” үндэсний форумын үеэр газар олголтын ил тод байдлыг онцлон авч үзэж, хотын захиргаа, бусад төрийн албадын төлөөлөгчид, иргэдийн оролцоотойгоор газар олголтын үед гарч байгаа гажуудлуудыг засч залруулах талаар

мэтгэлцэж, санал солилцсоны үр дүнд ил тод байдлыг нэмэгдүүлэх, гарсан зөрчил маргааныг шийдвэрлэх тал дээр онцлон анхаарах талаар санал зөвлөмж боловсруулж, бодлого боловсруулагчид болон олон нийтэд хүргэлээ. Форумын үр дүнд үндэслэн,

ННФ Үндэсний Соёмбо хөдөлгөөнд газрын асуудлаар иргэдийн зөвлөл ажлуулах, Улаанбаатар хотын захиргаа болон бусад эрх мэдэлтнүүдтэй хамтран газрын зөрчил маргааныг шийдвэрлэхэд иргэд идэвхтэй оролцох боломжийг хангахын тулд тэтгэлэг олгосон болно.

## ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЯРИА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Нээлтэй Нийгэм Форум Монгол Улс хаана яваа болон хаашаа явах ёстой талаар өргөн хүрээтэй бодлогын яриа хэлэлцүүлэг өрнүүлэх, эдийн засгийн голлох асуудлаарх судалгаа, хэлэлцүүлгийг сайжруулах явдалд байнга анхаарч ажиллахыг зорьж байна.

“Үндэсний хөгжлийн яриа хэлэлцүүлэг” хэмээх тусгай механизм бий болгох санаачилгыг ННФ 2005 оноос эхлүүлсэн бөгөөд энэ нь үндэсний хөгжлийн асуудлуудаар мэргэжилтнүүдийн дунд тогтмол уулзалт ярилцлага хийхийг дэмжих замаар бодлогын хувилбаруудыг тогтоон үнэлгээ өгөх, цаашлаад эдийн засгийн шийдвэрлэх сонголтуудыг хэлэлцэн тохироход хувь нэмрээ оруулах учиртай юм. Энэ төслийн өөр нэг хэсэг нь Монголын бодлого боловсруулагчид болон бодлогын хамтын нийгэмлэгийн

бусад хүмүүсийн оролцоотой цуврал лекц, хэлэлцүүлэг явуулах явдал юм. 2006 онд ННФ Монгол дахь эдийн засгийн эрх чөлөөний төвшин, өрсөлдөх чадвар, төсвийн ба татварын бодлогууд, сүүдрийн эдийн засаг ба бусад салбарын чиглэлээр хийж байгаа судалгаагаа үргэлжлүүлэх замаар эдийн засгийн бодлогын шинжилгээ, яриа хэлэлцүүлгийг хөхиүлэн дэмжиж ажиллалаа.

Пеннсилванийн их сургуулийг Ph.D. цолтойгоор төгссөн, Жоржиа мужийн Технологийн Институтын Сэм Нанны Олон улсын хэргийн сургуульд олон улсын улстөр, эдийн засаг, дэлхийн улстөрийн бодлого, Зүүн Ази ба Хятад судлалын хичээл заадаг профессор Фей-Линг Уанг 2006 оны зургадугаар сард ННФ-д зочилж лекц уншлаа. Ноён Уанг “Хятадын сэргэлт ба түүний

утга агуулга” сэдвээр илтгэл тавьж, Хятадын эдийн засгийн боломжит өсөлт ба Хятадтай хамтран ажиллахыг хүссэн бусад орны баримталж болох стратегийн боломжит хандлагуудын талаар ярьсан юм. Хөрш орныхоо талаар авч хэлэлцсэн энэ лекц нь судлаачид, эрдэмтэд, бодлого боловсруулагчдын хувьд сонирхолтой бөгөөд анхаарал татсан чухал сэдэв байв.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай ойлголтыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс Форум МУИС-ийн Эдийн Засгийн Сургуультай хамтран Мэрилэндийн их сургуулийн профессорыг урьж ирүүлэн уулзалт зохион байгуулсан. Тус их сургуулийн Эдийн засгийн факультетийн эрхлэгч, профессор Петер Муррел трансакцийн зардалтай холбоотойгоор эдүгээ эдийн засагчдын дунд нэрд гараад байгаа

институцийн онолын талаар лекц уншив. Түүний лекцийн ерөнхий санаа нь улстөрийн бодлого, иргэний ба хүний эрх, төр, засгийн үр нөлөөтэй байдал, зохицуулалтын дарамт, эрхзүйт төр, авилгын хяналттай холбоотой бодлогуудыг хэрэгжүүлэхэд институцүүдийн гүйцэтгэх үүргийн тухай байсан бөгөөд түүний дэвшүүлсэн санал шүүмжлэлүүд нь институцийн онолын үзэл баримтлалыг ойлгохыг хичээж буй оролцогчдод ихээхэн тус дөхөм боллоо.

ННФ-ын вэб портал сайт нь Форумын олон нийтэд хүрэх гол хэрэгслийн нэг гэдэг үүднээс барууны тэргүүлэх эдийн засагчдын бичсэн нийтлэлийг орчуулж бэлтгэн байрлуулж байна. Нийтлэл бүр вэб форумтай холбоотой учраас сонирхсон хэн бүхэн уг нийтлэлүүд, тэнд хөндөгдсөн асуудлуудын талаар санаа бодлоо бичих боломжтой юм.



Форумын үйл ажиллагааг  
хэрэгжүүлэх арга хэрэгсэл

НЭЭЛТЭЙ НИЙГЭМ ФОРУМ  
**2006**  
ЖИЛИЙН ТАЙЛАН



## ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

Улс орны хөгжлийн бодлогын холбогдолтой цогц мэдээллийг нэг цэгээс хүргэх зорилготой Хөгжлийн Мэдээллийн төвийн үйл ажиллагаа 2006 онд олон нийтэд улам бүр танигдаж, сүүлийн үеийн ном, судалгааны тайлан, үнэлгээ, хөгжлийн асуудлаарх шинэ мэдээлэл ашиглах хүний тоо нэмэгдэхийн хэрээр үйл ажиллагаа нь өргөжиж, үйлчилгээний хэв маягт ахиц дэвшил гарлаа.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ой, Соросын сан Монголд үйл ажиллагаа явуулж эхэлсний 10 жилийн ойг тохиолдуулан хөдөө орон нутгийн 250 сумын номын санд нийтдээ 20.000 ам. долларын үнэ бүхий 21 төрлийн ном хандивлав. Түүнчлэн өнгөрсөн

оны төгсгөлд МУИС-ийн төв номын сан, Эдийн Засгийн Сургууль, Санхүү Эдийн Засгийн Сургуулийн номын сан дээр Хөгжлийн Мэдээллийн төвийн “Мэдлэг түгээх булан”-г шинээр нээж Нээлттэй Нийгэм Форум болон Дэлхийн Банкнаас шинээр хэвлэн гаргаж байгаа англи, монгол хэл дээрх 1000 орчим шинэ номыг байрлуулан тухайн сургуулийн оюутан, багш нарт үйлчилж байна.

2005 оноос эхэлсэн хөдөө орон нутагт мэдээлэл түгээх ажиллагаа өргөжиж өнгөрсөн оны тавдугаар сараас аймгуудын номын сангаар дамжуулан сумдын номын сан руу ном хүргэж эхэллээ. Түүнчлэн дотоодын болон хилийн цэргийн ангийн номын санд

зарим гарын авлагыг тараав. Тайлант хугацаанд нийтдээ 15.000 орчим ном түгээжээ. Энэхүү мэдээлэл түгээх сүлжээг бэхжүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор хөдөө орон нутгийн номын санчдыг дэмжих “Сайн дурын хөтөлбөр” эхлүүлээ. Үг хөтөлбөрийн хүрээнд 21 аймгийн 42 номын санч электрон каталогид (Lib4U) ном бүртгэх, тус төвийн ном судалгаатай танилцан орон нутагт нь хэрэгцээ шаардлагатай байгаа мэдээллийг судлах, номын сангийн удирдлагын программтай танилцах, онлайн мэдээлэл болон бусад орны электрон номын сан ашиглах, мэдээлэл түгээх хялбар арга аргачлалд суралцах зорилгоор номын санч бүр Хөгжлийн Мэдээллийн төвд нэг долоо хоног ажиллаж байна.

Өнгөрсөн онд хамтрагч донор байгууллагуудтай түншлэн ажиллахад ахиц гарлаа. Дэлхийн Банкны Зүүн Өмнөд Азийн орнуудын Мэдээллийн төвүүдийн жилийн уулзалтад оролцож ижил төрлийн Төвүүдийн үйл ажиллагаатай танилцлаа. Мөн Азийн Хөгжлийн Банкны номын сангийн сүлжээнд албан ёсоор хамрагдаж тус Банкаас хэвлэгдэн гарч байгаа шинэ ном, судалгааг үнэ төлбөргүй авч эхлээд байна.

Тайлант хугацаанд бусад орны тэргүүлэх электрон номын сан, онлайн мэдээллийг танилцуулах уулзалт семинар, улс орны хөгжлийн асуудлаар лекц уншуулах, шинээр гарч байгаа номын нээлт зэрэг олон

нийтэд зориулсан арга хэмжээг зохион байгуулж байв. Тухайлбал, 2006 оны зургадугаар сард “Электрон мэдээллийн санг ашиглах нь”, 10 дугаар сард Дэлхийн Банкны Монголыг хариуцсан захирал, доктор Давид Долларын “Монгол Улсын хөгжлийн бодлогын түлхүүр” сэдэвт лекцүүдийг зохион байгуулж, төрийн болон ТББ, их дээд сургууль, хэвлэл мэдээллийн болон бизнесийн байгууллагыг төлөөлсөн 70-80 хүн оролцлоо.

Мэдээллийн төвийн үйлчилгээний ажлыг боловсронгуй болгох зарим шинэ ажлыг эхлээд байна. Тус Төвд ирж мэдээлэл авч байгаа үйлчлүүлэгчдийг бүртгэх, ямар төрлийн мэдээлэл авч байгааг судлах боломжтой Дэлхийн Банкны бүртгэлийн онлайн системийг (<http://lnweb18.worldbank.org/ext/ps.nsf/PicEntrySheet>) ашиглан үйлчилгээний статистикийг гаргадаг боллоо. Сонины хайчилбарыг электронжуулж тусгай мэдээллийн сан ([www.soros.org/mn/epapers](http://www.soros.org/mn/epapers)) бий болгосон нь номын санчид болон хэрэглэгчдийн талархлыг хүлээж байна.

Хөгжлийн Мэдээллийн төв өөрийн үйлчлүүлэгчид, харилцагч хөгжлийн агентлаг, судалгааны төв, номын сан, төрийн болон ТББ-уудын ажилтнуудад үнэ төлбөргүй, өргөн хүрээний мэдээлэл түгээхийн зэрэгцээ эдгээр байгууллага өөрсдийн гаргасан ном, товхимол, судалгаа шинжилгээний баримт материалыг тус Төвд өгч хувь нэмрээ оруулж байна .



## ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨР

Бодлого боловсруулах үйл явц, түүний хэрэгжилтэд иргэдийн идэвхтэй оролцоог хангахад дөхөм үзүүлж, улс орны хөгжлийн болон бодлогын өргөн хүрээтэй асуудлаар мэдлэг, мэдээлэл түгээх зорилготой Нээлттэй Нийгэм Форумын телевизийн хөтөлбөр 2006 онд тус бүр нь нэг цагийн үргэлжлэл бүхий 10 удаагийн “Форум” шууд нэвтрүүлгийг бэлтгэн Монголын үндэсний телевизээр орон даяар дамжууллаа. Нэвтрүүлэгт янз бүрийн ажил мэргэжлийн 250 орчим хүн биеэр оролцож байр сууриа илэрхийлсний зэрэгцээ нэвтрүүлгийн үеэр үзэгчид тухайн сэдвээр утсаар саналаа өгч байлаа.

2006 оны нэвтрүүлгүүд нь улстөрийн зөвшилцөл, хөдөлгөөн, намуудын гишүүнчлэл, ашигт малтмалын лиценз олголт, монголын ирээдүй зэрэг Монголын нийгэм, улстөр, байгаль орчны тулгамдсан асуудлыг хөндсөн билээ. “Форум” телевизийн хөтөлбөр нь нийгмийн анхаарлыг нэлээд татаж, иргэний нийгмийн төлөвшилт, бодлого боловсруулагчдын төвшинд зохих нөлөө үзүүлж чадсан хэдий ч Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн удирдлагын зүгээс нэвтрүүлгийн цацалтын төлбөрийг удаа дараа нэмэх шаардлага тавьснаас шалтгаалан энэ онд 10 нэвтрүүлэг бэлтгэн явуулаад үйл ажиллагаагаа зогсоосон болно.


## 2005 оны нэвтрүүлгүүдийн товч танилцуулга

<p>2006.01.19 ДОХ-Танд хаммаатай юу?</p>	<p>Нэгэнт бодитойгоор нүүрлэсэн эмчилгээгүй тахлын эсрэг төрийн бодлого ямар байх вэ? Сайд Л.Гүндалайгийн үзэж байгаагаар “зөвхөн бэлгэвч” ДОХ-ын эрсдлээс хамгаална. Мөн гэр бүлдээ үнэнч байх, тохиолдлын бэлгийн хавтлаас татгалзахыг сайд иргэддээ уриаллаа. Халдвар авсан тохиолдолд хүмүүс үүнийгээ эрт шинжлүүлж мэдэн хүний дархлааг сайжруулах эм бэлдмэл хэрэглэснээр олон жил наслах бололцоотой гэдгийг ч ХӨСҮТ-ийн эмч Нямхүү, МУЗН-ийн хөтөлбөрийн зохицуулагч Илиза нар хэлж байлаа. Нэвтрүүлэгт оролцогчид ДОХ-ын тухай нийгэмд айдас төрүүлэх маягаар таниулах биш, харин хүмүүст зөв ойлголт өгч зөв таниулах, хөдөө орон нутгийн болон мэс засалч, эх баригч эмч нарын мэдлэгийг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх талаар анхаарууллаа.</p>
<p>2006.01.12 Ард түмний санал</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр энэ өндөр албан тушаалд сонгогдсоноосоо хойш нэгэн асуудлаар ард түмний саналыг асуух ёстой гэсэн санааг хэдэнтээ илэрхийлээд байна. Тэр нь Ерөнхийлөгчийн засаглалыг сонгох эсэх тухай асуудал юм. Сүүлийн жилүүдэд Ерөнхийлөгчийн засаглалын үзэл санаа Монголд зуугуухан дэлгэрч байна. Судлаачид их дэмждэг болжээ. Ерөнхийлөгчийн засаглалын төлөө төрийн бус байгууллагууд хүртэл үүсчээ. Нэвтрүүлэгт Сонгогчдын Боловсрол Төвийн тэргүүн Р.Бурмаа, МУИС-ийн Хууль Зүйн сургуулийн дэд захирал, доктор Н.Лүндэндорж, Удирдлагын Академийн багш, доктор Х.Гүндсамбуу, Ерөнхийлөгчийн Засаглалыг Дэмжих Холбооны тэргүүн Р.Ууганбаатар, иргэн Д.Ламжав, улстөр судлаач А.Саруул, “Тав дахь соёл” нийгэмлэгийн тэргүүн Д.Болдхуяг, Улаанбаатар хотын Иргэдийн Хурлын төлөөлөгч Ж.Жанцан нарын хүмүүс оролцлоо.</p>
<p>2006.03.29 Намын гишүүн</p>	<p>Өнөөдөр төрийн албыг намаас ангид байлгах шаардлага нэгэнт бий болжээ. 2000 хүрэхгүй хүн амтай жижиг сум хүртэл Иргэдийн төлөөлөгчдийн хурлаа хийж чадахгүй болтлоо намчирхаж байна. Үнэн хэрэгтээ сум орон нутаг дахь намын анхан шатны байгууллага, гишүүд төвтэйгээ ямар ч холбоо хэлхээ байхгүй, тэнд намын бодлого мөрийн хөтөлбөр хэрэгжээд байгаа зүйл үгүй хэрнээ л иргэдийн хуралд намууд нэр дэвшүүлж, сумын цөөхөн сэхээтнүүд нь намаараа хуваагдан талцаж байна. Нэвтрүүлэгт оролцогчдын ихэнхи нь намууд чөлөөт гишүүнчлэлтэй байж, төрийг намаас салгах ёстой гэдэг дээр адил байр суурьтай байлаа.</p>



<p>2006.03.22 Ядуу аав, Баян аав</p>	<p>Мөнгө олох, өсгөх арга ухааны тухай их ярьдаг болжээ. Өмнөх үеийнхэн “Тунгалаг тамир” -ын Итгэлт баян”-аас бага сага суралцдаг байсан бол шинэ үе “Баян аав, ядуу аав” болон үүнтэй төстэй бусад ном хэвлэлээс суралцаж байх шиг. Нэвтрүүлэгт “Хас” банкны гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг, Санхүү, Эдийн Засгийн Дээд сургуулийн дэд захирал, “Амжилтын хөтөч” төвийн тэргүүн Т.Цэнд-Аюуш, “Монгол Даатгал” компанийн ерөнхий мэргэжилтэн З.Бадам, Эд Хөрөнгийн Эрхийн Улсын Бүртгэлийн Албаны дарга Д.Долгормаа, Монголын Хөрөнгө Оруулагчдын Эрхийг Хамгаалах Нийгэмлэгийн тэргүүн Б.Төрмөнх, “Эрдэнийн эргэлт” хадгаламж зээлийн хоршооны гүйцэтгэх захирал Г.Ширмэндорж, САПУ-гийн түрээслэгчдийн ҮЭ-ийн хорооны дарга Х.Нямдорж нарын хүмүүс оролцлоо.</p>
<p>2006.03.15 Монгол : Дараачийн 15 жилд</p>	<p>Манай орон ардчилал, зах зээлийн замд шилжин орсноос хойш 15 жил өнгөрлөө. Энэ хугацаанд улс орны хөгжлийн чиг баримжааг тусгасан 90 гаруй баримт бичиг боловсруулсан ч хэрэгжсэнгүй цаасан дээр үлджээ. Ирэх 15 жилийн хөгжлийн бодлого ямар байх талаар нэвтрүүлэгт оролцогчид мэтгэлцлээ.</p>
<p>2006.03.01. 20:00-21:00 Монголын ус</p>	<p>Албан ёсны судалгаагаар Монгол орны усны нөөц 34.6 км куб. Энгийнээр хэлбэл хааш хаашаа 34 км дөрвөлжин саванд Монголын хэрэглэж болох бүх ус багтана. Дэлхийн жишгээр Монгол ус ховортой оронд тооцогддог. Нийслэл Улаанбаатар хот гэхэд 20 жилийн дараа усгүй болно гэсэн судалгааг мэргэжилтнүүд дээхнэ хийжээ. Гэвч хоногт хэрэглэх усны хэрэглээ нь нэмэгдэж байгаагаас 20 биш харин тавхан жилийн дараа нийслэлийнхэн усгүй болно гэсэн тооцоог зарим судлаачид гаргаад байна. Энэ бол түгшүүр. Үнэхээр алт биш харин ус хайх, ус олборлох хэрэг Монгол улсад тулгараад байгаа юм биш үү? Монголчууд бид буга тарвагаа намнаж зөөгөөд дууссан, алт зэсээ ухаж зараад дуусч байна. Одоо усаа зарах л үлдлээ гэж үү? Сэтгүүлчийн асуултад усны салбарын ихэнхи мэргэжилтэн “усыг ашиглах, зарах цаг болсон хэмээн “ үзэж байгаагаа нэвтрүүлгийн үеэр илэрхийллээ.</p>
<p>2006.02.22. 20:00 21:00 Яагаад хөдөлгөөн...?</p>	<p>Иргэний хөдөлгөөнүүд гарч ирлээ. Тэд ямар ч асуудлыг шүүрч аваад тэмцэхэд хэзээд бэлэн байна. Өнөөдөр иргэний хөдөлгөөнүүдийн ээлжит шаардлагуудыг сонсох юм бол төрийг огцруулж, буулгах тухай л ярьж байна. Нэвтрүүлэгт улс төрч, орчуулагч Г.Бошигт, доктор, профессор С.Лочин, “Эрүүл Нийгэм” иргэний хөдөлгөөний ерөнхий зохицуулагч О.Магнай, “Эрс Шинэчлэл” хөдөлгөөний тэргүүн С.Ганбаатар, Монголын Ахмадын Чөлөөт Холбооны тэргүүн Г.Баасан нар оролцлоо.</p>

<p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">2006.02.15. Ашигт малтмалын лиценз</p>	<p>Оюу толгой, Таван толгой зэрэг онцгой орд газруудаас Монголчууд юм хүртэж чадах уу? Энэ асуултад бага ч болов хариулт олох зорилгоор ашигт малтмалын лиценз тойрсон асуудлаар энэ нэвтрүүлгийг бэлтгэв. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд ашиглалтын болон хайгуулын 6000 гаруй лиценз хүчинтэй байгаа бөгөөд тэрхүү лицензээр олгосон талбайн хэмжээ манай улсын нийт нутаг дэвсгэрийн тэн хагаст шахам хүрээд байна. Одоо лиценз эзэмшиж байгаа 1700 орчим аж ахуйн нэгж, иргэд Монголын газар доорхи баялгийг аль хэдийнэ хуваагаад авчээ. Гэхдээ энэ бүхний буруутан нь хуулийн дагуу лиценз авсан лиценз эзэмшигчид биш харин өнөөдөр үйлчилж байгаа 1997 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хууль гэж нэвтрүүлэгт оролцсон олон хүн хэлж байлаа. Тиймээс ч ирэх хаврын чуулганаар Ашигт малтмалын тухай хуулийг өөрчлөхдөө юуг анхаарах тухай ч нэвтрүүлэгт оролцогчид саналаа хэлэв. УИХ-ын гишүүн, Үйлдвэр Худалдааны Сайд Б.Жаргалсайхан лицензийн асуудлыг цэгцэлж хууль бус явдлыг таслан зогсооно, Монголын баялгийг ард иргэдэд, улсад хүртээмжтэй байдлаар ашиглахад анхаарна гэдгээ амаллаа.</p>
<p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">2006.02.08 Зөвшилцөл юу өгөв?</p>	<p>2004 оны УИХ-ын сонгуулиар сонгогчдын санал МАХН ба “Эх орон-Ардчилал” эвсэлд ерөнхийдөө тэнцүү хуваагдсаны дараа улстөрийн цоо шинэ нөхцөл байдал үүсч зөвшилцөл эхэлсэн. Зөвшилцөл юу болов, үргэлжилж байна уу? Ямар сургамж өгөв?</p> <p>Энэ тухай дэлгэрэнгүй ярилцсан нэвтрүүлэгт МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга С.Баяр, МАХН-ын нарийн бичгийн дарга Ё.Отгонбаяр, Ардчилсан Намын гүйцэтгэх зөвлөлийн гишүүн З.Энхболд, МУИС-ийн Хууль Зүйн сургуулийн дэд захирал Н.Лүндэндорж, мөн “Иргэдийн Альянс” төвийн дэд захирал Т.Ундарьяа, улстөр судлаач Э.Гэрэлт-Од, МСДН-ийн дарга А.Ганбаатар, Нийгэм-Эдийн Засгийн Судалгааны “Прогноз” хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, МУИС-ийн Хууль Зүйн сургуулийн багш Х.Тэмүүжин нар оролцлоо.</p>



## “www.forum.mn” ПОРТАЛ САЙТ

“Нээлттэй Нийгэм Форум” портал сайт нь Монгол дахь бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх үйл явц, бодлогын шийдвэрийн талаарх мэдээллээр олон нийтийг хангах, бодлогод хяналт тавих, үнэлэх зэрэг чиглэлээр 2006 онд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

### Нийтлэл

Монголын хөгжлийн талаарх олон янзын байр суурийг агуулсан дүн шинжилгээ бүхий 54 нийтлэл, өгүүллийг 2006 онд олны хүртээл болгосон байна. Чингэхдээ өмнөх онд улстөр, төсөв, мэдээллийн эрх чөлөөний асуудлууд түлхүү тусгагдсан байсныг харгалзан эдгээрээс бусад цөөнтэй тоотой өгүүлэл агуулсан сэдвүүдийг тодорхой хэмжээгээр хөндөхийг зорьсон болно. Үүний үр дүнд эдгээр сэдвээс гадна татвар, байгаль орчин, гадаад, дотоод бодлого, даяаршлын асуудлыг хөндсөн нийтлэлээр баяжсан бөгөөд эрдэмтэн судлаач 20, багш 20, сэтгүүлч 10, төрийн албан хаагч нэг, улстөрч нэг зэрэг давхардсан тоогоор 54 гаруй хүн өөрсдийн бичсэн нийтлэл, өгүүлэл нийлүүлжээ. Мөн “Орчуулгын нийтлэл” буланд гадаадын нэр хүнд бүхий авторуудын зохиол бүтээлээс орчуулж таниулах ажлыг үргэлжлүүлэн хийлээ.

### News headlines

2005 оны 11 дүгээр сараас эхлэн манай портал сайт тухайн өдрийн Монголын улстөр, эдийн засгийн онцлох үйл явдлын талаарх тойм мэдээллийг тогтмол хүргэж эхэлсэн нь 2006 онд дүр төрхөө бүрэн олсон бас нэг шинэлэг ажил болсон юм. Тойм өгүүллийг өдөр тутмын сонин хэвлэлүүдийн мэдээлэлд үндэслэн өдөр бүр байнга шинэчилдэг бөгөөд тайлант хугацаанд нийт 200 орчим шинэ мэдээлэл нэмэгдсэн байна.

## Тогтмол Явуулдаг ажиглалтууд

### Сонгууль

Улсын Их Хурлын болон Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн үр дүнд бий болсон улстөрийн нөхцөл байдалтай холбогдуулан Монголын улстөрийн хүрээнд өрнөж буй үйл явдлыг тогтмол мэдээлж байна. Мэдээллийг бэлтгэхдээ намуудын амлалт Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд хэрхэн хэрэгжиж буй байдлыг илүүтэй харгалзан үздэг бөгөөд энэ хэсэгт 2006 онд 100 гаруй мэдээллийг шинээр оруулжээ. Тэрчлэн бодлогын асуудлаар улстөрчдийн хэлсэн үг байр суурийг харуулсан “Хэн юу хэлэв” буланг үргэлжлүүлэн ажиллуулж байна. Өмнөх жилүүдтэй харьцуулахад энэхүү ажиглалтын мэдээллийн тоо цөөрсөн нь энэ он сонгуулийн жил биш байсантай холбоотой юм.

### Уул уурхай – Хөгжил

2006 онд Монголын уул уурхайн салбарын хувьд ихээхэн онцлог жил болж өнгөрлөө. Үүнийг энэ салбарын хурдацтайгаар холбоотойгоор олон нийтийн үүсгэл санаачилгын үндсэн дээр орон нутгийн болон газар шорооны төлөөх иргэдийн хөдөлгөөнүүд олноор байгуулагдан нэгдэн нягтрах үйл явц өрнөсөнтэй холбон тайлбарлаж болох юм.

Монголын парламент 2006 оны долдугаар сард анх удаа олон нийтийн хөдөлгөөнүүдийн хяналт дор Ашигт малтмалын хуулийг шинэчлэн баталлаа. Гэсэн хэдий ч иргэний нийгмийн байгуулагууд энэ шинэ хуульд төдийлөн сэтгэл ханамжтай бус байна. “Айвенхоу Майнз” компанитай хийх Засгийн газрын гэрээ хойшлогдож, Засгийн газар болон иргэдийн хөдөлгөөн, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөлтэй ажлын хэсэг байгуулагдав.

Уул уурхайн салбарын үйл явцад холбогдох 70 гаруй мэдээллийг олон нийтэд хүргэлээ. Ашигт малтмалын шинэ хуулийн төслийг портал дээр байрлуулан олон нийтийн санаа бодлыг авах зорилгоор саналын хуудас ажиллуулав.

### “Төсвийн үйл явц”

Тус портал нь 2004 оноос эхлэн жил бүрийн улсын төсвийг УИХ-аар хэлэлцэн батлах үйл явц, төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой багц мэдээллүүдийг тогтмол толилуулдаг болсон. Тайлангийн хугацаанд 2006 оны төсвийн тодотгол, тухайлбал, төсөв ерөнхийлөн захирагчдын зарлага, орлого, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж,

гадаад зээлийн ашиглалт, төлбөр зэрэгт холбогдох нийт 70 мэдээ, мэдээллийг түгээлээ. 2007 оны улсын төсвийн дэлгэрэнгүй төслийг бүрэн эхээр нь веб сайтад байрлуулж, олон нийтийн санал бодлыг хүлээн авлаа.

Монгол Улсын татварын тогтолцоог боловсронгуй болгох үүднээс татварын багц хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж буйтай холбогдуулан “Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн төсөл, Онцгой албан татварын хуулийн төсөл, Хүн амын орлогын албан татварын хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн төсөл, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн төсөл зэрэг бичиг баримтыг сайтад байруулан мөн санал авч эхэлсэн байна. Эдгээр хуулийг парламентаар хэлэлцэх явцын талаарх мэдээллүүдийг цаг тухайд түгээлээ.

### **“Жижиг, дунд бизнес”**

Монгол Улс дахь жижиг, дунд бизнесийн салбарын хөгжлийн асуудлуудад холбогдох мэдээллийг хүргэхээр 2005 оны дөрөвдүгээр сараас “Жижиг, дунд бизнес” сэдвийн дор ажиглалтын буланг ажиллуулж эхэлснийг үргэлжлүүлэн холбогдох хууль тогтоомж, хандивлагчдын үйл ажиллагаа, энэ салбарын талаарх судалгаа, тайлан, үнэлгээ зэрэг 30 орчим мэдээллийг багцлан оруулаад байна.

## **Бодлогын асуудал**

“Бодлогын асуудал” буланд Татварын хуулийн багц хуулийн шинэчилсэн найруулгын төслүүд, УИХ-ын сонгуулийн хуулийн төсөл, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн төсөл, Мэдээллийн технологийн тухай хуулийн төсөл, Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл, Ашгийн төлөө бус байгууллагын тухай хуулийн төсөл, Ашигт малтмалын тухай хуулийн төсөл зэрэг баримт бичиг, тэдгээртэй холбоотой судалгаа, санал зөвлөмжийг багцлан толилуулсан байна. Тайлант хугацаанд 40 гаруй мэдээллийг шинээр оруулсан бөгөөд эдгээр асуудлаар нийт 50 гаруй хүн санал бодлоо илэрхийлжээ.

## **Эх сурвалж**

Тайлангийн хугацаанд Монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийн сэдвээр донор байгууллагууд болон бусад судалгааны төвийн хийсэн 60 орчим шинэ судалгааг бүрэн эхээр нь pdf форматаар байрлуулав. Мөн бодлогын асуудлаар хэвлэгдэж буй ном товхимол, гарын авлагуудыг танилцуулжээ.

2006 онд манай портал сайтад нийт 150 гаруй мянган хүн, өдөрт дундажаар 600 орчим хүн нэвтэрчээ. 600 орчим мэдээллээр порталын мэдээллийн сан арвижсан байна. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд нийт 570000

хүн, сард дундажаар 15000, өдөрт дундажаар 518 хүн нэвтэрч хэрэгцээтэй мэдээллээ авсны зэрэгцээ 1500 орчим

хүн тухайн сэдэв, асуудлаар санал бодлоо илэрхийлжээ.

## БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Нээлттэй Нийгэм Форумын Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан судлаачдын тайлан нь эдүгээ бодлого боловсруулах үйл явцад хувь нэмрээ оруулахын зэрэгцээ бодлогын холбогдолтой асуудлаар олон нийтийг мэдээллээр хангах бие даасан дүн шинжилгээний эх сурвалж болж эхэллээ. Анх 2003 онд Монгол дахь бодлогын судалгааны хүчин чадлыг бүрдүүлэх, чанартай сайн судалгаагаар дамжуулан бодлого боловсруулах үйл явцад нөлөөлөх зорилгоор хэрэгжиж эхэлсэн энэ хөтөлбөр 2006 оны байдлаар 22 бодлогын судлаачтай

болоод байна.

ННФ-ын Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах судлаачдыг нээлттэй зарлан, өрсөлдөөнт шалгаруулалтаар сонгон авдаг бөгөөд судлаачдад аргазүйн болон агуулгын дэмжлэг үзүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээгээр хангадаг. Судалгаа үргэлжлэх хугацаа асуудлын онцлогоос шалтгаалан дунджаар 6-9 сар байдаг.

2006 оны Бодлогын судалгааны хөтөлбөрт нийт 50 гаруй судлаач материалаа ирүүснээс найман судлаачийг сонгон авч ажиллуулж байна. Үүнд:

Г.Алтанзаяа	Татвар цуглуулах механизм
Б.Бат-Өлзий	Тэтгэврийн бодлогын хэрэгжилт
Б.Бат	Голланд өвчин: Уул уурхайн салбараас бусад салбарт үзүүлэх нөлөө
Б.Батмөнх	Төсөв, санхүүгийн төвлөрөл ба орон нутгийн бие даасан байдал
Д.Бямбажав	Шийдвэр гаргах үйл явцад төрийн бус байгууллагын оролцоог дэмжсэн хууль эрх зүйн орчин
А.Энхбат	Засгийн газрын зардлын үр ашгийг дээшлүүлэх арга зам
П.Гантөмөр	Албан бус сектор ба татвар
Т.Мөнх-Очир	Боловсон хүчний бодлого: Уул уурхайн салбарын хэрэгцээ ба боловсролын салбарын нийлүүлэлт

Бодлогын судалгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцдаа ННФ нь өөрийн дотоод хүчин чадлыг бэхжүүлсээр ирлээ. Энэ жилээс эхлэн бодлогын

судалгааны хөтөлбөрийн хүрээнд явагдах сургалтуудын заримыг ННФ-ийн ажилтнууд өөрсдөө боловсруулан хэрэгжүүлж байна.

## ■ ХЭВЛЭН НИЙТЛЭЛ

Бодлого боловсруулах, хянах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд тухайн асуудлаарх бодит мэдээлэл, судалгаа шинжилгээний дүн, адил төстэй орны туршлага, олон улсын хандлага, өөрийн орны нөхцөл байдлын талаарх цэгцтэй мэдээллээр хангах нь юу юунаас чухал болж байна. Ингэснээрээ тухайн асуудлаар олон нийт үнэн зөв мэдээлэлтэй болж улс орны хөгжлийн асуудлыг ойлгох, оролцох хүсэл эрмэлзлэл нэмэгдэж, мэдлэг мэдээлэлтэй иргэдийн оролцоо утга төгөлдөржинө гэж үзэж буй юм.

Нээлттэй Нийгэм Форум 2003 оноос эхлэн иргэдийг мэдээллээр хангахад нэмэр хандив оруулах зорилгоор бодлогын судалгаа шинжилгээний тайлан, иргэдэд зориулсан гарын авлага, номзүйн цуврал, орчуулгын ном зэргийг хэвлэн нийтэлж олны хүртээл болгож байна. 2006 онд нийт 30 орчим ном, бүтээл хэвлэгдсний дотор бодлогын холбогдолтой судалгааны тайлан 13,

иргэдэд зориулсан гарын авлага 4, номзүйн цуврал 2, уул уурхай, төсвийн асуудлаарх орчуулгын 3 ном олны хүртээл боллоо.

Мөн зарим судалгааны тайлан тодорхой давтамжтайгаар жил тутам хэвлэгдэн гарч эхэллээ. Тухайлбал, Монгол Улсын Эдийн засгийн эрх чөлөөний тоймыг энд дурдаж болох юм.

Шинээр хэвлэгдсэн ном, судалгааны тайланг хөдөө орон нутгийн номын сан (аймаг, сумын), их дээд сургуулийн номын сан, бодлого боловсруулагчид, зарим ТББ, донор байгууллагуудад түгээж ирлээ. Мөн Форумын хүрээнд зохиогдож буй олон нийтийн хэлэлцүүлэг, уулзалт, ярилцлагын үеэр оролцогсдод үнэ төлбөргүй тарааж байна. Өнгөрсөн оноос зарим сэдвийн ном, судалгааны тайлан тодорхой хэрэглэгчдийн хүрээнд танигдан хямдралтай үнээр худалдаалагдаж эхэллээ.

## 2006 онд хэвлэгдсэн ном

1	Төрийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тогтолцоог боловсронгуй болгох нь /Бодлогын судалгааны тайлан/
2	Монголд эрдсийн сан байгуулах шаардлага, арга зам /Бодлогын судалгааны тайлан/
3	Монгол Улсын хөдөө орон нутаг дахь Мэдээлэл Холбооны Үйлчилгээний хүртээмж, тулгамдсан асуудлууд /Бодлогын судалгааны тайлан/
4	Монгол Улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Зүүн Хойд Азийн бүс нутагтай тээврийн дэд бүтцээ нэгтгэх боломж /Бодлогын судалгааны тайлан/
5	Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлэх /Бодлогын судалгааны тайлан/
6	Орон нутаг эдийн засгаа бие даан хөгжүүлэх боломж /Бодлогын судалгааны тайлан/
7	Монголын нутгийн удирдлагын асуудалд холбогдох ном зүй
8	Монгол дахь авилгын асуудалд холбогдох ном зүй
9	Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний тойм – 2005
10	Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний тойм – 2006
11	Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан 2005-2006 /Судалгааны тайлан/
12	Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга: Зөвлөлдөх бүлгийн тайлан
13	Өргөдөл, гомдлоо хэрхэн гаргах вэ? /Иргэдийн гарын авлага/
14	Хууль зүйн туслалцаа авах /Иргэдийн гарын авлага/
15	Та хотын хүн боллоо /Иргэдийн гарын авлага/
16	Өмгөөллийн стратеги /Өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага/
17	Нээлттэй төсвийн индекс /Судалгааны тайлан/
18	Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачилга: Сурвалж бичиг
19	Төрийн үйлчилгээний мониторинг /ТББ-уудын төрийн үйлчилгээнд хийсэн мониторингийн тайлан
20	Төрийн Ил Тод Байдал: Нийгмийн баялаг хуваарилалт /Форумын эмхтгэл/
21	ОУИТБС-д анхаарлаа хандуулъя
22	Шударга ёс тогтооцгооё: Алтны үнэ өртгийг тооцох нь
23	Боловсролын салбарын санхүүжилт, үр ашиг, тэгш байдал /Судалгааны тайлан/



Түүнчлэн Нээлттэй Нийгэм Форум Монсудар хэвлэлийн газартай хамтран эхлүүлсэн орчуулгын төслийн хүрээнд хэвлэгдэх сүүлийн гурван ном Колин Робсоны “Бодит ертөнцийг судлахуй”, Франсис Фукуямагийн “Сүүлчийн хүн ба түүхийн төгсгөл”, Морис Дювержегийн “Улс төрийн байгууламж” номууд тайлант хугацаанд хэвлэлээс гарч хэрэглэгчдийн гарт хүрлээ. Төслийн хүрээнд хэвлэсэн өмнөх есөн номын тодорхой хувь зарагдаж дараагийн ном орчуулж хэвлэх бага хэмжээний

санхүүгийн эх үүсвэр бий болж байна. Энэхүү төслийн зорилго нь орчуулагдсан номоос орж байгаа орлогоор дараа дараагийн хэрэгцээ шаардлагатай номуудыг монгол хэлнээ орчуулан хэвлэх санхүүгийн эх үүсвэр бий болгоход чиглэгдэж байгаа болно. Иймээс уг ажил нь иргэдийн танин мэдэхүй, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, нийгмийн сэтгэлгээний цаашдын хөгжилд түлхэц өгч дараагийн ном орчуулагдан хэвлэгдэх эрэлт хэрэгцээг бий болгоно гэж үзэж байна.

## Бусад хавсралт



НЭЭЛТЭЙ НИЙГЭМ ФОРУМ  
**2006**  
ЖИЛИЙН ТАЙЛАН

## “АЛБАДАН АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫГ ХЭВШҮҮЛЭХ” ТӨСӨЛ

Энэхүү төслийн зорилго нь хөнгөн, хөнгөвтөр гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд болон насанд хүрээгүй гэмт этгээдийг нийгэм хамт олны дунд хүмүүжүүлэх, нийгэмд тустай ажил хийснээр учруулсан гэм хороо төлөх боломжийг бий болгох, хүнд хөнгөн ямар ч гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусад хорих ёстой гэсэн хандлагыг өөрчлөх, иргэн болон хамт олны оролцооны шинэ хандлагыг эрүүгийн ял шийтгэлийн тогтолцоонд бий болгох явдал юм.


Энэ зорилгын хүрээнд ялтанг нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, улмаар засан хүмүүжих нөхцөл, боломж бүрдүүлэх чиглэлд түлхүү анхаарч байна. Төслийн хүрээнд эдүгээ 134 ялтан болон түүний гэр бүлийн гишүүдийг шууд туслалцааны үйлчилгээнд хамруулсан байна. Тухайлбал, ялтан бүртэй шийдвэр гүйцэтгэгчийн хамт хавтаст хэрэгтэй нь танилцаж, ялтангай ажиллах нийгмийн ажилтны хөтөлбөрийн дагуу ганцаарчилсан уулзалт хийх, анкет хөтлөн ялтанг нийгэмшүүлэх ажлыг төслийн нийгмийн ажилтан сэтгэл зүйчийн оролцоотойгоор зохион байгуулав. ДОХ-той Тэмцэх

Үндэсний Сан, Олон Улсын Энэрэлийн байгууллага, “Дэлхийн Зөн”, АДРА зэрэг зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж ялтанг нийгэмшүүлэх, түүний гэр бүлд дэмжлэг туслалцаа үзүүлэх арга хэмжээг авсан байна. Зохих хуулийн дагуу дүүргүүдийн тохижилт үйлчилгээний компани, Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг, Хүүхэд Асран Хүмүүжүүлэх Төв, БЗД-ийн Эрүүл Мэндийн Нэгдэл, Удирдлагын Академи, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв, Төмөр замын Хүүхдийн сектор, Сонгино хайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар, Английн Хүүхдийг Ивээх Сан, Энэрэл эмнэлэг зэрэг байгууллагад тухайн ялтны нас хүйс, ажил мэргэжил, хэргийн зүйл анги, хувийн зан төлөвшил зэргийг нь харгалзан үзэж ажиллуулжээ. Түүнчлэн тэднийг ажиллуулахад зориулж Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын дэмжлэгтэйгээр хөдөлмөрийн багаж хэрэгсэл авч хөдөлмөр хамгааллын хувцастай болголоо.

Ялыг оноож эдлүүлэх ажиллагаанд оролцдог нийт хүмүүсийг хамруулсан сургалтуудыг нийслэл, дүүрэг, орон нутагт тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж нийт 729 хүнийг

хамруулан гарын авлага, зөвлөмж, ном, арга зүйгээр хангаж баримтжуулсан болно. Тэрчлэн албадан ажил хийлгэх ялын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, ач холбогдлыг нь ойлгуулах үүднээс сонин сэтгүүлд өгүүлэл нийтлэл гаргах, тус ялын хэрэгжилтийн талаар бодит баримтад тулгуурласан нэвтрүүлгийг бэлтгэн

нэвтрүүллээ. “Албадан ажил хийлгэх ял бол ял шийтгэлийн өвөрмөц төрөл мөн” номыг хэвлэн нийтэлж холбогдох хуулийн байгууллагуудаар тараан, хууль эрх зүйн дээд сургуулиудын номын сангуудад хүлээлгэн өгсний зэрэгцээ зурагт хуудас хэвлэн улсын хэмээнд тараасан байна.



2003 оноос төслийг эхлүүлснээс хойш албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтангуудын тоо тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

2006 оны хувьд Улс тунхагласны 800 жилийг тохиолдуулан улсын хэмжээнд өршөөл үзүүлж, энэ ялаас 136 хүн өршөөлд хамрагджээ. Дээд шүүхээс авсан тоон үзүүлэлтээс харахад энэхүү ялын тоон үзүүлэлт бусад ялтай

харьцуулахад 0.6 хувиар өсчээ.

2003-2006 оны хооронд албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтангуудаас дахин гэмт хэрэгт холбогдсон эсэхэд судалгааг хийхэд дөрвөн хүн дахин гэмт хэрэгт холбогдсон байгаа бөгөөд ихэнх ялтан төслийн үр дүнд дахин гэмт хэрэгт холбогдохгүй байгааг харуулж байна.

Төслийн хамгийн чухал үр дүн нь тухайн ялын чиглэлээр ажиллах нийгмийн ажилтан сэтгэл зүйчийн орон тоог Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газарт бий болгосон явдал юм. Өөрөөр хэлбэл, ялтныг зөвхөн залхаах, цээрлүүлэх бус, засан хүмүүжүүлэх, цаашид гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан

сэргийлэх нийгмийн сэтгэл зүйн үйлчилгээг институтчилэн бэхжүүлжээ.

Төслийн үр дүнд албадан ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааны нэгдсэн стандарт жишиг бий болж улсын хэмжээнд хэрэгжиж эхлээд байна.

## “ДОРНО ДОРНО - ХИЛ ХЯЗГААРГҮЙ ТҮНШЛЭЛ” БҮСИЙН ХӨТӨЛБӨР

Дорно Дорно хөтөлбөр нь нээлттэй нийгмийг хөгжүүлэх, түүнийг бэхжүүлэх нөхцлийг бий болгоход чиглэсэн хүмүүсийн идэвх санаачилга, хамтын ажиллагаа, хил хязгааргүй түншлэлийг дэмждэг Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн бүсийн хөтөлбөр бөгөөд ННФ Монгол дахь үйл ажиллагааг нь хариуцан хэрэгжүүлж байна. Хөтөлбөр нь нээлттэй нийгмийн үзэл санааг бүсийн хэмжээнд бэхжүүлэхэд түлхэц болох шинэ санаа, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Хоёр буюу түүнээс дээш орныг хамарсан төслүүдийг дэмждэг болно.

Энэхүү хөтөлбөр нь орон нутгийн нөхцөл байдлыг сайн мэдэрч доороос гарч ирсэн санаачилгуудад анхаарлаа хандуулж, нээлттэй нийгмийг хөгжүүлэх нийтлэг зорилгод хүрэхийн тулд хүмүүс хил хязгаарыг харгалзахгүйгээр хүч хавсран ажиллах боломжийг нэмэгдүүлэхийг урт хугацааны зорилго болгодог юм. Хөтөлбөрийн хүрээнд бүсийн орнуудад зохиогдож буй шинэлэг санаа, арга туршлагаа хуваалцах зорилго бүхий арга хэмжээнд Монголын мэргэжилтэн, төлөөлөгчдийг хамруулж байна.

**Дорно-Дорно хөтөлбөрийн тэтгэлэгт хамрагдагсад /2006/**

Оролцогчдын нэрс	Байрлал	Хурал, семинар зохион байгуулагдсан газар болон агуулга	Огноо
1 С.Байгальтөгс Компьютер Технологийн Менежментийн Их Сургуулийн захирал	Ереван хот Армени улс	“Дээд боловсролд үндэсний кредит системийг нэвтрүүлэх нь : Туршлагууд болон сорилтууд” хурал	2006 оны 5 сарын 4-6,
2 Ю.Эрдэнэтуяа УИХ-ын Тамгын газрын мэргэжилтэн	Иссик-Кул Киргизстан улс	Төрийн бодлогын форум	2006 оны 11 сарын 30- 12 сарын 1
3 Б. Батзориг Цагдаагийн Академийн багш	Прага хот Чех улс	“Гэр бүлийн хүчирхийллийн хэргүүдэд цагдаагийн оролцоог нэмэгдүүлэх нь” семинар	2006 оны 11 сарын 24-27
4 М.Ичинноров Эмэгтэйчүүд-Манлайлал сангийн захирал	Сиаулай, Вилньос хот Литва улс	“Жендерийн тэгш байдлын шинэлэг стратегийг хөгжүүлэх нь: Гэр бүлд ээлтэй бодлого” сургалт	2006 оны 11 сарын 14-17
5 Б. Тогтохбаяр Сэтгүүлч	Сиаулай, Вилньос хот Литва улс	“Жендерийн тэгш байдлын шинэлэг стратегийг хөгжүүлэх нь: Гэр бүлд ээлтэй бодлого” сургалт	2006 оны 11 сарын 14-17
6 Б.Сугаржав ШШБЕГ-ын ахлах мэргэжилтэн	Братислав хот Словак улс	“Урт хугацааны хорих ял хоригдлуудын зан байдалд нөлөөлөх нь ” семинар	2006 оны 9 сарын 12-14
7 Х.Тэмүүжин МУИС-ийн ХЗДС-ийн багш	Ереван хот Армени улс	“Ардчиллын үйл явцын мониторинг” хурал	2006 оны 10 сарын 25-28,
8 С.Нарангэрэл МУИС-ийн ХЗДС-ийн захирал	Вилньос хот Литва улс	“Криминалистик ба эрх мэдэл: Гэмт хэргээс урьчилан сэргийлэх түншлэл” хурал	2006 оны 10 сарын 27-28

## САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Нийт зарцуулалт

\$ доллaр

Хөтөлбөр	Үйл ажиллагааны зардал	Бусад байгууллагад олгосон тэтгэлэг	Нийт зардал
<b>ЗАСАГЛАЛ</b>	<b>230,464</b>	<b>375,636</b>	<b>606,100</b>
Ил тод байдал	31,038	-	31,038
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	11,051	70,535	81,586
Нээлттэй ил тод төсөв	15,244	26,064	41,308
Төрийн үйлчилгээний мониторинг	14,134	155,854	169,988
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	47,731	86,008	133,739
Иргэдийн оролцоо ба мэдээллийн эрх чөлөө	7,150	6,775	13,925
Нутгийн болон төвлөрсөн удирдлага	7,399	-	7,399
Эрхзүйн туслалцаа	15,467	30,400	45,867
Төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалт	68,256	-	68,256
Боловсрол	12,995	-	12,995
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>	<b>92,618</b>	<b>107,000</b>	<b>199,618</b>
Эдийн засгийн эрх чөлөөний индекс	53,285	-	53,285
Орон нутгийн эдийн засгийн хөгжил	39,333	107,000	146,333
<b>БУСАД</b>	<b>1,230</b>	<b>7,905</b>	<b>9,135</b>
Дорно дорно хөтөлбөр	1,230	7,905	9,135
<b>ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЯВУУЛАХ АРГА ХЭРЭГСЭЛ</b>	<b>198,701</b>	<b>123,531</b>	<b>322,232</b>
Хөгжлийн мэдээллийн төв	27,879	20,000	47,879
Портал сайт	38,924	-	38,924
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр	47,590	100,455	148,045
Телевизийн хөтөлбөр	74,371	-	74,371
Олон нийтийн хэлэлцүүлэг	9,936	3,076	13,012
<b>ЗАХИРГАА</b>	<b>562,684</b>	<b>-</b>	<b>562,684</b>
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,085,697</b>	<b>614,072</b>	<b>1,699,769</b>

## Тэтгэлэгийн нийт зарцуулалт

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлэг хүртэгч	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Нийт зардал
<b>ЗАСАГЛАЛ</b>				
<b>Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө</b>				
Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчилийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих	Globe International, ТББ	40,640		40,640
Шилжилтийн үеийн нэвтрүүлэг хөтөлбөрийн агуулгын мониторинг	Хэвлэлийн хүрээлэн	29,895		29,895
<b>Нээлтэй ил тод төсөв</b>				
Засгийн газрын төсвийн мэдээлэл	Сангийн Яам-Эдийн засгийн Нэгдсэн Бодлого Төлөвлөлтийн Газар	13,500		13,500
Орон нутгийн төсвийн зарцуулалтыг иргэд хянах нь	Иргэний боловсрол төв	12,564		12,564
<b>Төрийн үйлчилгээний мониторинг</b>				
Төрөөс иргэдэд газар өмчлүүлэх /эзэмшүүлэх ашиглуулах/ үйлчилгээнд хийх мониторинг	Нийгмийн судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих төв	3,465		3,465
Шатахуун түгээх станц эрхлэх зөвшөөрөл олгох төрийн үйлчилгээнд мониторинг хийх нь	Хуульч Эмэгтэйчүүдийн холбоо	5,022		5,022
Үдийн цай хөтөлбөрийн мониторинг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн Өмнөговь дахь салбар	2,633		2,633
Улстөрийн намын тухай хуулийн санхүүжилтийн талаарх заалтуудын хэрэгжилтийн мониторинг	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн	12,657		12,657



**Тэтгэлэгийн нийт зарцуулалт**

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлэг хүртэгч	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Нийт зардал
Сурагчдаас авч буй хууль бус төлбөр хураамжийн мониторинг	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд хөдөлгөөн- Дархан Салбар	2,505		2,505
Халамж	CEDAW-Багануур дүүргийн салбар зөвлөл	9,381		9,381
Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай дансанд мониторинг хийх төсөл	Айвуун-ТББ	9,406		9,406
Тэргэнцэрийн зам	Тусламжийн тэргэнцэр сан	3,260		3,260
Орон нутгийн төсвийн мониторинг	Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор дахь салбар	3,072		3,072
Төрийн албанд ороход иргэдийн тэгш эрхийг хангах нь	Хуульч Эмэгтэйчүүдийн холбоо- Завхан салбар	2,908		2,908
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 67-р зүйлд хийх мониторинг/ шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа	Хөдөлмөрийн эрх зүй судлаачдын холбоо	13,706		13,706
Цэцэрлэгийн хүүхдийн хоолны хангамж ойлчилгээ	Амжилтын томъёо-Өмнөговь аймаг	3,004		3,004
Орон нутаг дахь иргэдийн оролцоо	Либераль эмэгтэйчүүдийн оюуны сангийн Өмнөговь аймгийн салбар зөвлөл	5,579		5,579
Сурах бичгийн хүртээмж	Либераль эмэгтэйчүүдийн оюуны сан	2,527		2,527

## Тэтгэлэгийн нийт зарцуулалт

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлэг хүртэгч	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Нийт зардал
"Voice"- Халамжийн үйлчилгээний мониторинг төсөл	Нийгмийн халамж Хамтын Ажиллагааны Сан	4,564		4,564
Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн мониторинг	Эрүүл мэндийн боловсролын зөвлөгөө, мэдээллийн Төв	3,927		3,927
Бидний эрх зөрчигдөөд байна: ХБИ-н зорчих нөхцлийн талаар төрөөс баримтлах бодлогод хийх мониторинг	Төмөр сан	3,372		3,372
Нийгмийн халамжийн тухай хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийн байдалд мониторинг хийх	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудыг дэмжих "Гэгээ Мандал" сан	7,675		7,675
Говь-Алтай аймгийн олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагаанд хийх мониторинг	Иргэний Боловсрол Төв-Говь-Алтай	2,575		2,575
Хөдөлмөрийн хуулийн 111-р зүйлийн хэрэгжилт	Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Чөлөөт Үйлдвэрчний эвлэл	8,066		8,066
Авилгын эсрэг хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийн явцад хийх мониторинг	Транспаренси Интернейшнл	22,250		22,250
Улаанбаатар хотын газар олголтод мониторинг хийх	Үндэсний Соёмбо хөдөлгөөн	24,300		24,300
<b><i>Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга</i></b>				
ОУИТБС-ын бага хурал, Баку	Э.Сумъяа		1,320	1,320

**Тэтгэлэгийн нийт зарцуулалт**

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлэг хүртэгч	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Нийт зардал
ОУИТБС-ын бага хурал, Баку	Б.Батжаргал		1,350	1,350
ОУИТБС-Бүсийн иргэний нийгмийн уулзалт, Гүрж	Б.Болдбаатар		1,291	1,291
ОУИТБС-Бүсийн иргэний нийгмийн уулзалт, Гүрж	Л.Ариунчимэг		1,291	1,291
ОУИТБС-Уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн орлогын тайланд дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах	Эрхүү хотын УААА-н Дээд Сургууль Төгсөгчдийн Монголын Холбоо	8,237		8,237
ОСИТБС-ын ажлыг эрчимжүүлэхэд нөлөөлөх төсөл	Миний Монголын Газар Шороо хөдөлгөөн	8,530		8,530
ОУИТБС-ыг дэмжих төсөл	Онон Улз Голынхон хөдөлгөөн	5,905		5,905
ОУИТБС-ыг дэмжих төсөл	Уугуул Хөдөлгөөн	5,120		5,120
ОУИТБС-ыг дэмжих төсөл	Сэлэнгэ аймаг дахь "Өглөө таймс" сонин	4,975		4,975
Олборлох Үйлвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга	Ц.Ганболд		8,670	8,670
Уул уурхайн гэрээний тухай сургалт, Бишкек	Ц.Ганболд		1,388	1,388
Уул уурхайн гэрээний тухай сургалт, Бишкек	А.Батпүрэв		1,388	1,388
Нутаг усаа хамгаалах хөдөлгөөнүүдийн эвслийн хурал	Р.Нарангэрэл		1,287	1,287
Олборлох салбарын ил тод байдлыг дэмжих төсөл	Зориг сан	6,701		6,701

## Тэтгэлэгийн нийт зарцуулалт

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлэг хүртэгч	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Нийт зардал
Уул уурхайн компаниудын Ил Тод байдлын рейтинг	Ил тод байдал сан	15,695		15,695
Уул уурхайн салбарын ил тод байдал, ТББ-ын эвслийн судалгааны аялал, Гана Улс	Ч.Дэлгэрмаа		3,215	3,215
Уул уурхайн салбарын ил тод байдал, ТББ-ын эвслийн судалгааны аялал, Гана Улс	Ц.Ганболд		3,215	3,215
Уул уурхайн салбарын ил тод байдал, ТББ-ын эвслийн судалгааны аялал, Гана Улс	Н.Дашзэвэг		3,215	3,215
Уул уурхайн салбарын ил тод байдал, ТББ-ын эвслийн судалгааны аялал, Гана Улс	О.Цэрэннадмид		3,215	3,215
<b>Иргэдийн оролцоо ба мэдээллийн эрх чөлөө</b>				
Хууль хэлэлцэх, батлах явц дахь иргэдийн оролцоо Братислав-сургалт	Д.Цэцэгмаа		1,355	1,355
Хууль хэлэлцэх, батлах явц дахь иргэдийн оролцоо Братислав-сургалт	Т.Оюунчимэг		1,355	1,355
Хууль хэлэлцэх, батлах явц дахь иргэдийн оролцоо Братислав-сургалт	З.Энхболд		1,355	1,355
Хууль хэлэлцэх, батлах явц дахь иргэдийн оролцоо Братислав-сургалт	Р.Рааш		1,355	1,355

**Тэтгэлэгийн нийт зарцуулалт**

\$ доллар

<b>Хөтөлбөр</b>	<b>Тэтгэлэг хүртэгч</b>	<b>Байгууллагад олгосон тэтгэлэг</b>	<b>Хувь хүнд олгосон тэтгэлэг</b>	<b>Нийт зардал</b>
Хууль хэлэлцэх, батлах явц дахь иргэдийн оролцоо Братислав-сургалт	Г.Баясгалан		1,355	1,355
Байгаль орчны асуудлаарх стратегийн өмгөөлөл	Хүний эрх хөгжил төв	30,400		30,400
<b><i>Орон нутгийн эдийн засгийн хөгжил</i></b>				
“Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх-Делта” төсөл	Бодлого судлалын төв	107,000		107,000
<b><i>БУСАД</i></b>				
<b><i>Дорно дорно хөтөлбөр</i></b>				
Дээд боловсролд үндэсний кредит системийг нэвтрүүлэх нь	С.Байгальтөгс		1,000	1,000
Урт хугацааны хорих ял хоригдлуудын зан байдалд нөлөөлөх нь “семинар Братислав хот	Ж.Сугаржав		1,128	1,128
Гэр бүлийн хүчирхийллийн хэргүүдэд цагдаагийн оролцоог нэмэгдүүлэх нь	Б.Батзориг		1,059	1,059
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх түншлэл	С.Нарангэрэл		1,108	1,108
Жендерийн тэгш байдлын шинэлэг стратегийг хөгжүүлэх нь	М.Ичинноров		1,250	1,250
Жендерийн тэгш байдлын шинэлэг стратегийг хөгжүүлэх нь	Б.Тогтохбаяр		1,250	1,250
Төрийн бодлогын форум	Ю.Эрдэнэтуяа		1,110	1,110

**Тэтгэлэгийн нийт зарцуулалт**

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлэг хүртэгч	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Нийт зардал
<b><i>Хөгжлийн мэдээллийн төв</i></b>				
Номын хандив	Улсын Төв Номын сан	20,000		20,000
<b><i>Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр</i></b>				
Шийдвэр гаргах үйл явцад ТББ-ын оролцоог дэмжсэн хууль эрх зүйн орчин	Д.Бямбажав		3,395	3,395
Татвар цуглуулах механизм	Г.Алтанзаяа		4,830	4,830
Тэтгэврийн бодлогын хэрэгжилт	Б.Бат-Өлзий		4,370	4,370
Төсөв санхүүгийн төвлөрөл ба орон нутгийн бие даасан байдал	Б.Батмөнх		6,100	6,100
Албан ёсны бус салбар болон татвар	П.Гантөмөр		3,520	3,520
Засгийн газрын зардлын үр ашгийг дээшлүүлэх арга зам	А.Энхбат		4,050	4,050
Уул уурхайн салбарын хэрэгцээ ба боловсролын салбарын нийлүүлэлт	Т.Мөнх-Очир		4,552	4,552
Хүнсний аюулгүй байдал-хяналтын механизмыг хэрхэн хангах	С.Мөнхбаатар		4,330	4,330
Инфляцийн эсрэг макро эдийн засгийн бодлогын шинжилгээ	Ц.Батсүх		3,610	3,610
Шилжмэл гентэй хүнсний хэрэглээ, түүний зохицуулалт	Б.Арвинбаяр		5,400	5,400

**Тэтгэлэгийн нийт зарцуулалт**

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлэг хүртэгч	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Нийт зардал
Хүнсний аюулгүй байдал- хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын хяналт	Х.Ганзориг		4,650	4,650
Аймаг, сумын ИТХ- д бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог дээшлүүлэх нь	Г.Түмэннаст		4,650	4,650
Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам, боломж	С.Оюунтуяа		6,047	6,047
Улс төрийн намуудыг шинэчлэхийн тулд гишүүдийн оролцоог дэмжсэн эрх зүйн орчин ба институционалыг сайжруулах нь	Э.Гэрэлт-Од		5,916	5,916
Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал ба иргэдийн оролцоо	С.Түмэндэлгэр		4,596	4,596
Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох нь	Д.Чимэддагва		5,200	5,200
Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үнэлгээ ба чанарыг сайжруулах нь	Л.Мөнх-Эрдэнэ		5,720	5,720
Улсын төрийн их сургуулийн удирдлагын тогтолцоог шинэчлэх нь: Боломжит шилдэг загварыг боловсруулахуй	Л.Мөнх-Эрдэнэ		4,800	4,800

**Тэтгэлэгийн нийт зарцуулалт**

\$ доллар

<b>Хөтөлбөр</b>	<b>Тэтгэлэг хүртэгч</b>	<b>Байгууллагад олгосон тэтгэлэг</b>	<b>Хувь хүнд олгосон тэтгэлэг</b>	<b>Нийт зардал</b>
Эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх боломж, шаардлага	Ч.Базар		4,200	4,200
Төрийн бодлого дахь эрчимжсан мал аж ахуйн асуудлууд	Ө.Батсайхан		5,900	5,900
ЕБС-ийн сурах бичгийг үнэ төлбөртэй болгох бодлого	Д.Нарантуяа		4,619	4,619
<b><i>Олон нийтийн хэлэлцүүлэг</i></b>				
Хөдөлмөрийн хуулийн 111-р зүйлийн хэрэгжилт	Д.Бурчинов		3,076	3,076
<b>Нийт зарцуулалт</b>		465,016	149,056	614,072



## ■ НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

### Удирдах зөвлөл:

Ж.Нарантуяа	<a href="mailto:narantuya@mail.parl.gov.mn">narantuya@mail.parl.gov.mn</a>
Д.Жаргалсайхан	<a href="mailto:djargal@yahoo.com">djargal@yahoo.com</a>
Ц.Ариунаа	<a href="mailto:ariunaa@artscouncil.mn">ariunaa@artscouncil.mn</a>
П.Цэнгүүн	<a href="mailto:ptsenguun@altantaria.mn">ptsenguun@altantaria.mn</a>
Л.Төр-Од	<a href="mailto:turod@khasbank.mn">turod@khasbank.mn</a>
Д.Ганбат	<a href="mailto:ganbat@academy.org.mn">ganbat@academy.org.mn</a>
Х.Тэмүүжин	<a href="mailto:temuujin@lawyer.com">temuujin@lawyer.com</a>

### Гүйцэтгэх захирал:

П.Эрдэнэжаргал	<a href="mailto:jargal@forum.mn">jargal@forum.mn</a>
----------------	--

### Ажилтнууд:

Ж.Баярцэцэг	Засаглалын асуудал хариуцсан менежер	<a href="mailto:bayar@forum.mn">bayar@forum.mn</a>
Н.Дорждарь	Эдийн засгийн асуудал хариуцсан менежер	<a href="mailto:dorjdari@forum.mn">dorjdari@forum.mn</a>
Б.Мөнхсоёл	Эдийн засаг, хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан менежер	<a href="mailto:soyoloo@forum.mn">soyoloo@forum.mn</a>
А.Гэрэлмаа	Нийгэм, Боловсролын асуудал хариуцсан менежер	<a href="mailto:gerelmaa@forum.mn">gerelmaa@forum.mn</a>
Д.Энхцэцэг	Хөтөлбөрийн зохицуулагч	<a href="mailto:enkhee@forum.mn">enkhee@forum.mn</a>
Д.Долгорсүрэн	Хөтөлбөрийн туслах ажилтан	<a href="mailto:fassistant@forum.mn">fassistant@forum.mn</a>
О.Оюунсаруул	Хөтөлбөрийн туслах ажилтан	<a href="mailto:passistant@forum.mn">passistant@forum.mn</a>
Д.Балжид	Мэдээллийн төвийн менежер	<a href="mailto:baljid@forum.mn">baljid@forum.mn</a>
Д.Баярмаа	Мэдээллийн төвийн туслах ажилтан	<a href="mailto:dircassist@forum.mn">dircassist@forum.mn</a>
Д.Гантуяа	Порталын ерөнхий редактор	<a href="mailto:gantuya@forum.mn">gantuya@forum.mn</a>
Т.Батбаатар	Веб мастер	<a href="mailto:batbaatar@forum.mn">batbaatar@forum.mn</a>
Д.Жавхлан	Санхүү, захиргааны захирал	<a href="mailto:javkhlan@forum.mn">javkhlan@forum.mn</a>
Д.Аюуш	Нягтлан бодогч, тэтгэлэгийн менежер	<a href="mailto:ayush@forum.mn">ayush@forum.mn</a>
Д.Өлзийбадрах	Мэдээлэл сүлжээний зохицуулагч	<a href="mailto:ulzii@forum.mn">ulzii@forum.mn</a>
Т.Отгонбаяр	Захирлын туслах	<a href="mailto:reception@forum.mn">reception@forum.mn</a>
Б.Баатар	Жолооч	<a href="mailto:baatar@forum.mn">baatar@forum.mn</a>
Ч.Саруул	Жолооч	<a href="mailto:saruul@forum.mn">saruul@forum.mn</a>
Г.Цэдэвхүү	Жолооч	<a href="mailto:tsedev@forum.mn">tsedev@forum.mn</a>
Ш.Ганчимэг	Захиргааны туслах ажилтан	<a href="mailto:ganaa@forum.mn">ganaa@forum.mn</a>

Нийтлэг Имэйль: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)